

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ОФИЦЕР, АХЛАГЧ, ГЭРЭЭТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД
МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ МЭРГЭЖЛИЙН ЖАГСААЛТ**

Нэг. Ерөнхий цэргийн мэргэжлээр

1. Стратеги-тактик, команд штабын
2. Командын /мотобуудлага, танк/
3. Танк, ЯЦБМ /ХТ/-ны механик жолооч
4. ЯЦБМ /ХТ/, танкийн наводчик-оператор
5. Буудагч (мэргэн буудагч, гранатомётчин, пулемётчин)
7. Сургалтын төвийн оператор

Хоёр. Цэргийн тагнуулын мэргэжлээр

А. Ерөнхий цэргийн тагнуулын мэргэжлээр

1. Стратеги-тактик, команд штабын
2. Командын мэргэжлээр

Б. Тусгай томилолтын тагнуулын мэргэжлээр

1. Стратеги-тактик, команд-штабын
2. Командын
3. Тусгай томилолтын тагнуулын мэргэжилтэн

В. Шүхрийн мэргэжлээр

1. Шүхрийн зааварлагч
2. Шүхэрчин

Г. Радио тагнуулын мэргэжлээр

1. Стратеги-тактик, команд штабын
2. Командын
3. Радио тагнуулын мэргэжилтэн

Д. Тусгай радио холбооны мэргэжлээр

1. Командын
2. Тусгай радио холбооны мэргэжилтэн

Е. Цэргийн орчуулагч

Гурав. Цэргийн холбооны мэргэжлээр

1. Стратеги-тактик, команд-штабын
2. Холбооны инженерийн
3. Радио телеграфчин, радиотелеграфчин, телеграфчин
4. Шим мандлын станцын механикч
5. Олон, цөөн сувгийн радиорелейний станцын механикч
6. Цахилгаан тэжээлийн станцын механикч
7. Олон хосын болон өндөр үелзлийн кабелийн мэргэжилтэн
8. Олон сувгийн нягтруулгын хэрэгслийн механикч
9. Холбоо, мэдээлэл техник хэрэгслийн засварчин
10. Шууданчин
11. Программчин
12. Цэргийн мэдээллийн мэргэжилтэн

Дөрөв. Химийн цэргийн мэргэжлээр

1. Химийн стратеги-тактик, командын офицер
2. Химийн командын офицер
3. Химийн техникийн офицер (тооцоо-шинжилгээний)
4. Химийн техникийн офицер (засвар үйлчилгээний)
5. Химийн оператор
6. Химичин-засварчин
7. Химийн нярав, зааварлагч
8. Химичин-тагнуулчин
9. Химичин-цэвэрлэгч
10. Химичин-ариутгагч

Тав. Цэргийн инженерийн мэргэжлээр

1. Стратеги-тактик. команд-штаб
2. Команд
3. Инженер техникийн офицер /ашиглалтын инженер, инженер-механик, зам, гүүр, барилгын машин механизмын инженер/
4. Сапёрчин, тэсэлгээчин, мина-тэсэлгээний техникч
5. Инженерийн тусгай зориулалтын машины дарга, механикч-жолооч, засварчин, инженерийн техник хэрэгслийн техникч
6. Ус хангалтын мэргэжилтэн /ус хангалтын сапёрчин, станцын дарга, усны шинжээч, өрөмдөгч/
7. Ус гатлалтын мэргэжилтэн /гүүрчин, моторчин, усанд шумбагч, гүүр барилгын хэрэгслийн техникч/
8. Замын мэргэжилтэн /замчин, замын машины механик жолооч, оператор, засварчин, скрейперчин. грейдерчин, индүүчин, бульдозерчин, тракторчин, эксковаторчин/
9. Цахилгаан техникийн мэргэжилтэн /цахилгаанчин, дизельчин/
10. Инженер төхөөрөмжийн мэргэжилтэн /хийц угсрагч, хийц бэлтгэгч, хөрөөчин, өнгөлөн далдлагч, краны машинист/

Зургаа. Агаарын довтолгооноос хамгаалахын мэргэжлээр

1. Стратеги-тактик, команд штаб
2. Команд (зенитийн пуужин, зенитийн артиллери, радиотехник)
3. Инженер техник (зенитийн пуужин, радиотехник, цаг уур, эрчим хүчний тоноглол)
4. Пуужин чиглүүлэх станцын тоот номер
5. Харвах суурийн тоот, номер, харвалтыг удирдах системийн оператор
6. Шалган хэмжих хөдөлгөөнт станцын тоот, номер
7. Угсрах, залгах, сумлах хэрэгслийн тоот, номер
8. Цэнэглэгч хэрэгслийн тоот, номер
9. Радиолокацын станцын тоот, номер
10. РПК-ийн оператор
11. Цахилгаан механикч, дизельчин
12. Планшетчин уншигч /бичигч/, ХУБ-ын оператор
13. Тагнуулчин хол хэмжигч
14. Байлдааны машины болон бууны дарга, харвагч, бууны тоот, номер

Долоо. Цэргийн нисэхийн мэргэжлээр

1. Байлдааны онгоц /нисдэг тэрэг/-ний нисгэгч
2. Тээврийн нисэх онгоц /нисдэг тэрэг/-ны нисгэгч
3. Нисэх иженер /борттехникч/
4. Нислэгийн хөдөлгөөний зохицуулагч /нислэгийн удирдагч/
5. Нислэг-хянагч /штурман/
6. Удирдах байрын штурман
7. Радиоэлектрон тоноглолын техникч
8. Зэвсэглэлийн техникч
9. Их бие хөдөлгүүр /ашиглалт/-ийн механикч
10. Цахилгаан, тусгай тоноглолын техникч
11. Их бие, хөдөлгүүр /ашиглалт/ -ийн техникч
12. Радиоэлектрон тоноглолын механикч
13. Цэргийн нисэхийн холбооны инженер, техникч
14. Радиоэлектрон тоноглолын механикч
15. Цахилгаан тоноглолын механикч
16. Зэвсэглэлийн механикч

Найм. Артиллерийн мэргэлжээр

1. Стратеги-тактик, команд штаб
2. Артиллерийн команд
3. Артиллерийн байр зүйч-тагнуулчин, хол хэмжигч
4. Артиллерийн тооцоочин
5. Авиа зүйч
6. Газрын тагнуулын станц /СНАР-10/-ын оператор
7. ТЭЗС-ийн оператор
8. Бууны захирагч-наводчик

Ес. Ар тал, зэвсэглэл, техникийн мэргэжлээр

1. Стратеги-тактик, команд штабын мэргэжлээр
2. Командын /Ар талын төрөл мэргэжлээр/
3. Инженер-техникийн мэргэжилтэн /офицер/
4. Инженер –техникийн мэргэжилтэн /ахлагч/
5. Пуужин, артиллерийн зэвсэглэлийн мэргэжлээр (офицер)
6. Пуужин, артиллерийн зэвсэглэлийн мэргэжлээр (ахлагч)
7. Авто хуягт танкийн инженер, техникийн мэргэжлээр
8. Авто хуягт танкийн засварчин мэргэжлээр
9. Цэргийн эмнэлгийн команд
10. Цэргийн эмнэлгийн их эмч
11. Цэргийн эмнэлгийн бага мэргэжилтэн (бага эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ариун цэврийн орон тооны зааварлагч)
12. Цэргийн эдийн засагч

Арав. Цэргийн соёл хүмүүжлийн мэргэжлээр

1. Ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтын мэргэжилтэн

АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ОФИЦЕР, АХЛАГЧ, ГЭРЭЭТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД
ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ЭЗЭМШИХЭД ТАВИГДАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. Ерөнхий цэргийн мэргэжлээр

III зэрэг	II зэрэг	I зэрэг
1. Стратеги-тактик, команд штабын мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Дайн, цэргийн урлагийн түүх, Монгол Улсын цэргийн урлаг, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг зэвсэгт тэмцэлд ашиглах онолын үндэс</p> <p>2. Хөрш болон дэлхийн томоохон гүрнүүдийн цэргийн стратегийн үндэс</p> <p>3. Монгол улсын төрийн батлан хамгаалах бодлого, түүний үндсэн баримт бичгүүдийн агуулга</p> <p>4. Бригадын үндсэн төрлийн байлдааны ажиллагааны үндэс</p> <p>5. Нэгтгэл, анги, салбарын байлдааны бэлэн байдал, дайчилгааны үндэс</p> <p>6. Нэгтгэл, ангиудын байлдааны ажиллагааны дэмжлэг, бүх талын хангалтын үндэс</p> <p>7. Байлдаан болон тайван цагийн цэргийн удирдлага, штабын алба</p> <p>8. Байлдааны баримт бичгүүдийн агуулга, боловсруулах журам</p> <p>9. Гадаадын орнуудын армийн нэгдэл, нэгтгэлийн зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны боломж, оператив, тактикийн ажиллагааны үндэс</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. МУ-ын цэргийн урлагийн хөгжлийн чиг хандлага</p> <p>2. Хөрш болон дэлхийн томоохон гүрнүүдийн цэргийн стратегийн хөгжил</p> <p>3. Монгол улсын батлан хамгаалах тогтолцоо үзэл баримтлал, үндэсний цэргийн стратеги</p> <p>4. Зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэх үндэс</p> <p>5. Цэргийн удирдлагын үндэс</p> <p>6. Нэгтгэл, анги, салбарын байлдааны боломжийг тооцох аргачлал</p> <p>7. Нэгтгэл, анги, салбарын байлдах чадварыг сэргээн босгох арга хэмжээ</p> <p>8. Гадаад орнуудын армийн нэгтгэл ангиудын оператив-тактикийн ажиллагааны үндэс</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Цэргийн урлаг, цэргийн шинжлэх ухаан, түүний бүрэлдэхүүн хэсгүүд</p> <p>2. Дэлхийн цэрэг улс төрийн байдал, зэвсэгт тэмцлийн хөгжил, чиг хандлага</p> <p>3. Улс орныг дайны байдалд шилжүүлэх үндэс</p> <p>4. Бүс нутгийн болон орон нутгийн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлага, сургамж</p> <p>5. Түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг бэлтгэх үндэс</p> <p>6. Зэвсэгт хүчний байлдааны боломжийг дээшлүүлэх арга замууд</p> <p>7. Цэргийн заль мэх</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Зураг дээр болон газар орон дээр цагийн байдлыг тогтоон ажиллагааны хувилбаруудыг гаргадаг байх</p> <p>2. МББр-ын түвшинд байлдааны ажиллагааны шийдвэрийг гаргаж, анги, салбаруудад байлдааны үүрэг тавих</p> <p>3. Нэгтгэл, ангиудын удирдага, харилцан ажиллагаа, бүх талын хангалтыг зохион байгуулах</p> <p>4. Байлдааны баримт бичгүүдийг тогтсон шаардлага, стандартын дагуу боловсруулж чаддаг байх</p> <p>5. Цэргийн ерөнхий бэлтгэлийн ба мэргэжлийн</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Оператив-тактикийн төрөл бүрийн тооцоо хийх</p> <p>2. Холбооны хэрэгслээр болон биеэр анги, салбарын ажиллагааг удирдах, харилцан ажиллагааг зохион байгуулах</p> <p>3. Нэгтгэл, анги, салбаруудыг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх,</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг бэлтгэх ажлыг зохион байгуулах</p> <p>2. Зэвсэгт хүчний дэлгэн байгуулалт, шилжүүлэн бүлэглэлтийг зохион байгуулах</p> <p>3. Ерөнхий зориулалтын цэрэг, нэгтгэлийн түвшинд шийдвэр гаргах, төрөл, тусгай мэргэжлийн цэргийн хооронд</p>

нормативуудыг бүрэн биелүүлдэг байх 6. Дайчилгааны жигдрэлтийн сургуулийг төлөвлөх 7. Төрөл бүрийн тооцоо, санал, шийдвэрийг илтгэх	дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулж, дайчилгааны жигдрэлтийн сургуулийг зохион байгуулах 4. Оперативын өнгөлөн далдлалтыг төлөвлөх	харилцан ажиллагаа, удирдлага, бүх талын хангалтыг зохион байгуулах 4. Удирдлагын байран дээр штаб, удирдлагын байгууллагын ажиллагааг зохион байгуулах
---	--	--

2. Командын /мотобуудлага, танк/ мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин

1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдааны үндэс 2. Мотобуудлага, танкийн батальон хүртэлх салбарын тактикийн ажиллагааны үндэс 3. Мотобуудлага, танкийн батальон хүртэлх салбарын бэлэн байдал, дайчилгааны үндэс 4. Бүх төрлийн зэвсэг, байлдааны техник, табель хэрэгслийн үүрэг зориулалт, хүчин чадал, байлдааны боломж 5. Гадаад орны армиудын нэгтгэл, ангийн зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны боломж 6. Анги, салбарын тактикийн болон штабын бэлтгэлийн үндэс 7. Тактикийн болон жижиг бүлгийн байлдааны ажиллагааны үндэс	III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна: 1. Төрөл бүрийн тактикийн тооцоо хийх аргачлал 2. Анги, салбарын байлдааны бэлэн байдал, бэлэн байдлын зэргүүдэд хэрэгжүүлэх арга хэмжээ 3. Байлдааны талбар дахь тактикийн заль мэх, өнгөлөн дадлалт 4. Тактикийн салбаруудын байлдааны дэмжлэг, бүх талын хангалтыг зохион байгуулах 5. Цэргийн удирдлагын тогтвортой байдлыг хангах арга замууд 6. Улсын хил хамгаалалтын тактикийн ажиллагааны үндэс	II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна: 1. Алдагдсан байлдах чадварыг сэргээх арга, журам 2. Төрөл мэргэжлийн цэргийн салбаруудыг ашиглах тактикийн үндэс 3. Анги, салбарын дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах, дайчилгааны жигдрэлтийг зохион байгуулах үндэс
--	--	--

б. Ур чадварын түвшин

1. Зураг дээр болон газар орон дээр цагийн байдлыг тогтоон ажиллагааны хувилбаруудыг гаргадаг байх 2. МББ хүртэлх нэгжид байлдааны шийдвэрийг гаргаж, анги, салбаруудад байлдааны үүрэг тавих 3. Анги, салбарын удирдага, харилцан ажиллагаа, бүх талын хангалтыг зохион байгуулах 4. Байлдааны баримт бичгүүдийг тогтсон шаардлага, стандартын дагуу боловсруулж чаддаг байх 5. Салаа, салбарын гал, маневр, тактикийн ажиллагааг удирдах, харилцан ажиллагааг зохион байгуулах 6. Тактикийн хичээлийг төлөвлөж удирдах	III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна: 1. Төрөл бүрийн тактикийн тооцоо хийх 2. Анги, салбарын дайчилгааны жигдрэлтийг төлөвлөх 3. Штабын дадлага, тактикийн хээрийн сургуулийг төлөвлөх	II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна: 1. Тактикийн салбаруудтай явуулах байлдааны буудлагатай болон буудлагагүй ТХС-ийн төлөвлөгөөг бүрэн хэмжээгээр боловсруулж тооцоог бодож чаддаг байх 2. Анги, салбарын дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулж, дайчилгааны жигдрэлтийг удирдах 3. КШС, тактикийн хээрийн сургуулийг төлөвлөх, зохион байгуулах
---	--	---

3. Танк, ЯЦБМ /ХТ/-ны механик жолоочийн мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин

1. Байлдааны журманд танк, ЯЦБМ /ХТ/-ийн эзлэх байр, үүрэг, харилцан ажиллагааны үндэс 2. Танк, ЯЦБМ /ХТ/-ийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, тэдгээрт байрласан тусгай зориулалтын багаж төхөөрөмжийн	III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна: 1. Экипажийн аль нэг гишүүний үүрэг, ажиллагаа	II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна: 1. Экипажийн бүх гишүүдийн үүрэг, ажиллагаа
--	---	--

<p>үүрэг зориулалт, хүчин чадал, байлдааны боломж</p> <p>3. Танк, ЯЦБМ /ХТ/-ийн тусгай тоноглолыг ажиллуулах журам, заавар</p> <p>4. Танк, ЯЦБМ /ХТ/-д хэрэглэгддэг ШТМ, тусгай шингэний зориулалт, ашиглах заавар</p> <p>5. Танк, ЯЦБМ-ийн жолоодлогын дүрэм, дасгалуудын агуулга, хийх дараалал</p> <p>6. Танк, ЯЦБМ дээр хийх үзлэг, техникийн үйлчилгээний дараалал, ажлын багтаамж</p> <p>7. Буудлага, жолоодлогын үе дэх аюулгүйн ажиллагааны дүрэм заавар</p> <p>8. Танк, ЯЦБМ /ХТ/-ны зэвсэглэлийг тусгалд оруулах, тэдгээрт гарсан гацаа саадыг арилгах аргачлал</p>	<p>2. Танк, ЯЦБМ /ХТ/-ны сэргээн сайжруулах үйлчилгээ</p> <p>3. Танк, ЯЦБМ /ХТ/-ийг богино хугацааны хадгалалтад тавих, хадгалалтаас гаргах журам, технологи</p>	<p>2. Танк, ЯЦБМ /ХТ/-д урсгал болон дунд засвар хийх журам, технологи</p> <p>3. Танк, ЯЦБМ /ХТ/-ийг удаан хугацааны хадгалалтад тавих, хадгалалтаас гаргах журам, технологи</p>
---	--	--

б. Ур чадварын түвшин

<p>1. Танк, ЯЦБМ /ХТ/-д тохиолдсон гэмтлийг тодорхойлж чаддаг</p> <p>2. Танк, ЯЦБМ /ХТ/-д үзлэг, үйлчилгээ хийж чаддаг байх</p> <p>3. Танк, ЯЦБМ /ХТ/-ийн жолоодлогын бүх төрлийн дасгалуудыг сайнаас Онц дүнтэй гүйцэтгэж чаддаг</p> <p>4. Танк, ЯЦБМ /ХТ/ дээр хийх нэг бүрийн нормативуудыг сайнаас Онц үнэлэлттэй хийж чаддаг байх</p> <p>5. Танк, ЯЦБМ /ХТ/-ны тусгай тоноглолыг ажилд бэлтгэн ажиллуулж чаддаг</p> <p>6. Танк, ЯЦБМ /ХТ/-ны зэвсэглэлийг тусгалд оруулж, тэдгээрт гарсан гацаа саадыг арилгадаг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Экипажийн аль нэг гишүүнийг орлон ажиллах чадвартай</p> <p>2. Танк, ЯЦБМ-нд сэргээн сайжруулах үйлчилгээ хийж чаддаг</p> <p>3. Танк, ЯЦБМ-ийг түр хугацааны хадгалалтанд шилжүүлэх, хадгалалтаас гаргахад хийгдэх ажлуудыг гүйцэтгэж чаддаг</p> <p>4. Танк, ЯЦБМ-нд тохиолдсон гэмтлийг засварлаж чаддаг</p> <p>5. Шинээр механик жолоочийн мэргэжил эзэмшигчдэд дадлага олгох дадлага, туршлагатай байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Экипажийн 2-оос доошгүй гишүүнийг орлон ажиллах чадвартай байх</p> <p>2. Танк, ЯЦБМ-д урсгал засвар хийж гүйцэтгэх чадвар, дадлагатай байх</p> <p>3. Танк, ЯЦБМ-ийг удаан хугацааны хадгалалтад шилжүүлэх, хадгалалтаас гаргахад хийгдэх ажлуудыг гүйцэтгэж чаддаг.</p>
--	---	--

4. ЯЦБМ /ХТ/, танкийн наводчик-операторын мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Байлдааны журманд ЯЦБМ /ХТ/, танкийн байр, үүрэг, харилцан ажиллагааны үндэс</p> <p>2. Буудлагын онолын үндэс</p> <p>3. ЯЦБМ /ХТ/, танкийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, тэдгээрт байрласан тусгай зориулалтын багаж, төхөөрөмжийн үүрэг зориулалт, хүчин чадал, байлдааны боломж</p> <p>4. Тоот, салаа, салбаруудаар галын үүрэг биелүүлэх үед өгөгдөх команд дохионы агуулга</p> <p>5. ЯЦБМ /ХТ/, танкийн зэвсэглэлээр буудах арга барил /буудлагад бэлтгэх, буудлага үйлдэх, буудлага зогсоох, тэдгээрийг тусгалд оруулах/</p> <p>6. Шөнө болон онцгой нөхцөлд нэг буюу бүлэг цельд гал</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Байлдааны машины тоотын аль нэг гишүүний үүрэг</p> <p>2. Буудлага явуулах аргууд, галт байрыг сонгох, гал засварлах аргачлал</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Тоот, тасгийн захирагчийн үүрэг</p> <p>2. Тоотын бүх гишүүдийн үүрэг</p>
---	---	---

<p>явуулах, целийг сонгох, галыг бүлэглэн хуваарилах, хөдөлгөөн эхэлсний дараа целийг илрүүлж устгах зарчим, дараалал</p> <p>7. Буудлага хийх үеийн аюулгүйн ажиллагааны заавар</p> <p>8. Байлдааны ажиллагааны талбар дахь целүүдийн илрэгдэх шинж чанарууд</p> <p>9. ЯЦБМ /ХТ/, танкаар буудах буудлагын дасгалуудын нөхцөл, онцлог</p> <p>10. ЯЦБМ /ХТ/, танкийн зэвсэглэлийн гацаа, саадыг арилгах, тэдгээрт засвар, үйлчилгээ хийх технологи</p>		
б. Ур чадварын түвшин		
<p>1. Төрөл бүрийн аргуудаар цель заах дадлага эзэмшсэн</p> <p>2. Өдөр болон хязгаартай үзэгдэх орчинд байлдааны талбарт хяналт үйлдэж бие дааж целийг илрүүлэн устгаж чаддаг</p> <p>3. Төрөл бүрийн аргаар цель хүртэлх холын зайг тодорхойлж чаддаг</p> <p>4. Буудлагын курст заагдсан дасгалуудыг Сайнаас Онц үнэлэлттэй биелүүлдэг</p> <p>5. Зэвсэг техник дээр хийх нэг бүрийн нормативуудыг Сайнаас Онц үнэлэлттэй биелүүлдэг</p> <p>6. Буудлагын үед илэрсэн гацаа саадыг арилгаж чаддаг</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тоотын аль нэг гишүүнийг орлон ажиллах чадвар эзэмшсэн</p> <p>2. Буудлагын үр дүнгээр галыг засварлах чадвартай байх</p> <p>3. Шинээр наводчик-операторын мэргэжил эзэмшигчдэд дадлага олгох заах аргын чадвартай байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Тоотын даргыг орлон ажиллах чадвартай байх</p>
5. Буудагч (мэргэн буудагч, гранатомётчин, пулемётчин) мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Эзэмшсэн буудлагын зэвсгийн үүрэг, зохион байгуулалт, ТӨ</p> <p>2. Буудлагын зэвсгийн буудлагын онолын үндэс</p> <p>3. Буудлагын зэвсгээр буудах арга барил /буудлагад бэлтгэх, буудлага үйлдэх, буудлагын зэвсгийг тусгалд оруулах/ буудлагын курс, дүрэм заавар</p> <p>4. Шөнө болон онцгой нөхцөлд цельд гал явуулах, целийг сонгох, целийг устгах зарчим, дараалал</p> <p>5. Буудлага хийх үеийн аюулгүйн ажиллагааны заавар</p> <p>6. Байлдааны ажиллагааны талбар дахь целүүдийн илрэгдэх шинж чанарууд</p> <p>7. Буудлагын зэвсгийн сум, галт хэрэгслийг ялгаж мэддэг байх</p> <p>8. Буудлагын зэвсгээр буудах буудлагын дасгалуудын нөхцөл, онцлогуудыг мэддэг байх</p> <p>9. Тасаг, салааны бүрэлдэхүүнд байлдаан явуулах үндэс</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Өөрийн үндсэн үүргээс гадна ЯЦБМ / ХТ/-ийн зэвсэглэлийн буудлагын онолын үндэс</p> <p>2. Буудлага явуулах аргууд, гал засварлах арга</p> <p>3. Тасгийн захирагчийн үүрэг, ажиллагаа</p> <p>4. Байлдааны талбарт хөдөлгөөн үйлдэх, амьд гарах, өнгөлөн далдлах тусгай арга техник</p> <p>5. Байлдааны хос, гурвалаар ажиллах үндэс</p> <p>6. Өөртөө болон нөхөртөө эмнэлэгийн анхан шатны тусламж үзүүлэх арга</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Салааны захирагчийн үүрэг</p> <p>2. Еренхий цэргийн салбаруудын байлдааны ажиллагааны үндэс</p> <p>3. Жижиг бүлгээр дайсны ар тал, жигүүрт тагнуул, хорлон сүйтгэх ажиллагааг явуулах арга тактик</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Төрөл бүрийн аргуудаар цель заах дадлага эзэмшсэн</p> <p>2. Өдөр болон хязгаартай үзэгдэх орчинд байлдааны талбарт хяналт үйлдэж, целийг илрүүлэн бие дааж устгаж чаддаг</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Буудлагын бүх терлийн зэвсгээр буудах</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Буудлагын зэвсгийн буудлага, галын</p>

<p>3. Төрөл бүрийн аргаар салхины хурд, цель хүртэлх холын зайг тодорхойлж чаддаг</p> <p>4. Автомат, мэргэн буудагчийн винтовоор буудах дадлага чадвар бүрэн эзэмшиж, буудлагын курст заагдсан дасгалуудыг “В”-ээс дээш үнэлэлттэй биелүүлдэг байх</p> <p>6. Буудлагын үед илэрсэн гацаа саадыг арилгаж чаддаг байх</p> <p>4. Өнгөлөн далдлах, газар орны хамгаалах шинж чанарыг ашиглах</p>	<p>дадлага, чадвар эзэмшсэн байх</p> <p>2. Буудлагын үр дүнгээр галыг засварлаж чаддаг байх</p> <p>3. Шинээр буудагч мэргэжил эзэмшигчдэд дадлага олгох заах аргын чадвартай байх</p> <p>4. Байлдааны талбарт шилжилт хөдөлгөөн хийх, галт байр солих, хот дотор болон ойрын зайн хурдан буудлага үйлдэх</p>	<p>бэлтгэл сургалтыг зохион байгуулах</p> <p>2. Байлдааны талбарт тасаг, бүлгийн гал удирдах</p>
--	--	--

7. Сургалтын төвийн оператор мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Ерөнхий цэргийн байлдааны үндэс</p> <p>2. Хариуцсан объектынхоо кабель шугамын бүдүүвч, сургуулийн төвийн тоног төхөөрөмжүүдийн ажиллах зарчим, зохион байгуулалт, дүрэм заавар</p> <p>3. Кабель шугам, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, монтажийн ажлын дараалал</p> <p>4. Цахилгаан тоног төхөөрөмжтэй ажиллах үеийн цахилгаан техникийн аюулгүйн ажиллагааны дүрэм, буудлага явуулах тоног төхөөрөмжтэй ажиллах үед хэрэгжүүлэх арга хэмжээнүүд</p> <p>5. Бүх төрлийн буудлагын курсын дасгалуудын онцлог, шаардагдах байны тоо, хэмжээ</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна</p> <p>1. Өөрийн гүйцэтгэх үүргээс гадна нэг шат дээгүүр албан тушаалтны үүргийг судалсан</p> <p>2. Цахилгаан тоног төхөөрөмжийн монтаж болон засвар үйлчилгээ, өвөл, зуны ашиглалтанд оруулах үйлчилгээний ажлын агуулга</p> <p>3. Сургуулийн төвийн объектуудын кабель шугамын хэлхээг боловсруулах, түүний талаар тодорхой мэдлэгтэй байх</p> <p>4. Хөдөлмөр хамгааллын дүрмийг мэддэг байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Сургуулийн төвд байгаа бүх тоног төхөөрөмжүүдийн хүчин чадал, ажиллах журмыг мэддэг байх</p> <p>2. Тактикийн цагийн байдалд тохирсон байны цагийн байдлыг зохиож буудлагын талбайг төхөөрөмжлөх мэдлэгтэй байх</p>
--	--	---

б. Ур чадварын түвшин

<p>1. Хариуцсан объектынхоо тоног төхөөрөмж, аппарат хэрэгсэлд техникийн үзлэг хийж эвдрэл гэмтлийг засаж чаддаг байх</p> <p>2. Цахилгаан гүйдэлд нэрвэгдсэн, түлэгдсэн болон хийгээр хордсон хүмүүст анхны тусламж үзүүлж чаддаг байх</p> <p>3. Буудлагын үед хөдөлгөөнт мотолебедка, цахилгаан станцтай холбоо барих, буудлага хийж байгаа секторт хяналт тавих чадвар эзэмшсэн</p> <p>4. Буудлага хийх үед буудлагын зохион байгуулалтыг хариуцан хийх чадвартай байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тактикийн цагийн байдалд тохирсон байны цагийн байдлын дагуу талбайг төхөөрөмжилж чаддаг байх</p> <p>2. Сургуулийн төвийн тоног төхөөрөмж, цахилгааны монтажийн засвар үйлчилгээг бие дааж хийх чадвар, дадлагатай</p> <p>3. Цахилгаан техникийн болон галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг урьдчилан зохион байгуулах чадвартай байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Сургуулийн төвийн байгууламж, тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүйн ажиллагааны дүрмийн талаар бие бүрэлдэхүүнд хичээл заах арга, туршлага эзэмшсэн</p> <p>2. Тактикийн цагийн байдалд тохирсон байны цагийн байдлыг зохиож бие бүрэлдэхүүнийг удирдан буудлагын талбайг төхөөрөмжилж чаддаг</p>
--	--	---

Хоёр. Цэргийн тагнуулын мэргэжлээр

А. Ерөнхий цэргийн тагнуул

III зэрэг	II зэрэг	I зэрэг
1. Стратеги-тактик, команд штабын мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Зэвсэгт хүчний операци, байлдааны ажиллагааны үндэс 2. Операц /байлдаан/-ийн ажиллагаанд ерөнхий цэргийн тагнуулын төлөвлөлт, зохион байгуулалт, удирдлага 3. Тагнуулын байгууллагуудын үүрэг, ажиллагаа 4. Төрөл мэргэжлийн цэргийн тагнуулыг төлөвлөх зохион байгуулах үндэс 5. Тагнуулын байлдааны баримт бичгүүдийн агуулга 6. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны боломж, стратеги, оператив-тактикийн ажиллагааны үндэс 7. Оперативын болон тактикийн тагнуулын хүч хэрэгслийн байлдааны боломж, ажиллагаа</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын цэргийн стратеги, оператив-тактик гарч буй өөрчлөлтүүд 2. Стратеги, оперативын болон тактикийн тагнуулын хүч хэрэгслийг ашиглах журам, төлөвлөлт, зохион байгуулалт 3. Бүс нутгийн цэрэг-стратегийн үнэлгээний аргачлал</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Дайн, зэвсэгт тэмцлийн түүхэн сургамж, хөгжил өөрчлөлт 2. Улс орны аюулгүй байдлыг тагнуулын болон цэргийн арга хэрэгслээр хангах үндэс 3. Болзошгүй дайсан, байлдааны ажиллагааны театр, түүнд дэлгэгдэх цэрэг, зэвсгийн бүрэлдэхүүн, ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэх</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Зэвсэгт хүчин, цэргийн бүлэглэл, нэгтгэл, ангийн удирдлагыг тагнуулын мэдээ, мэдээллээр тасралтгүй хангах 2. Цагийн байдлыг тогтоон тагнуулын хүч хэрэгслийг ашиглах санал, дүгнэлт гаргах 3. Төрөл бүрийн тактикийн болон тагнуулын тооцоо, өгөгдөхүүн бэлтгэх 4. Тагнуулын байлдааны баримт бичгүүдийг тогтоосон шаардлага, стандартын дагуу боловсруулах 5. Тагнуулын салбарууд болон МББр-ын тагнуулын хүч хэрэгсэлтэй явуулах тусгай тактикийн хээрийн сургуулийн бодлого төлөвлөгөөг боловсруулж, холбогдох тооцоо өгөгдөхүүнийг бэлтгэх 6. Цэргийн байр зүйн зурагт өөрийн болон эсрэг талын операц /байлдаан/-ийн ажиллагааг дүрслэх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын цэргийн стратеги, оператив-тактик гарч буй өөрчлөлтүүдийг дүгнэх 2. Стратеги, оперативын болон тактикийн тагнуулын хүч хэрэгслийг ашиглах санал боловсруулах, тагнуулын төлөвлөлтийг хийх 3. Бүс нутгийн цэрэг-стратегийн үнэлгээг гаргах</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Дайн, зэвсэгт тэмцлийн түүхэн сургамж, хөгжил өөрчлөлтийн талаар мэдээ, дүгнэлт бэлтгэх 2. Улс орны аюулгүй байдлыг тагнуулын болон цэргийн арга хэрэгслээр хангах ажиллагааг зохион байгуулах 3. Болзошгүй дайсан, байлдааны ажиллагааны театр, түүнд дэлгэгдэх цэрэг, зэвсгийн бүрэлдэхүүн, ажиллагааны талаар мэдээлэл бэлтгэх, зураг хөтлөх</p>
2. Командын мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдаан, түүнд тагнуул зохион байгуулах үндэс 2. Мбб хүртэлх салбаруудын үндсэн төрлийн байлдаан 3. Тагнуулын объектын тагнагдах шинж тэмдэг, тагнуул явуулах үндсэн аргууд 4. Тагнуул зохион байгуулах үндэс</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Байлдааны талбар дахь тагнуулын байгууллагуудын ажиллагаа 2. Мббрын үндсэн төрлийн байлдаан 3. Төрөл бүрийн тактикийн болон тагнуулын</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Тагнуулын бэлтгэл сургалтын төлөвлөлт, зохион байгуулалт 2. Газрын навигацын аппарат ТНА-3 бүтэц, зохион байгуулалт, ажиллагаа</p>

<p>5. МББр-ын ерөнхий цэргийн тагнуулын хүч хэрэгслийн боломж, тагнуулын байгууллагуудын үүрэг</p> <p>6. Онцгой нөхцөлд тагнуул зохион байгуулах онцлог</p> <p>7. Ажиллаж буй салбарынхаа тагнуулын бүх зэвсэг, байлдааны техник, табель хэрэгслийн үүрэг, зориулалт, хүчин чадал, байлдааны боломж, ашиглалт, хадгалалт, засвар үйлчилгээний горимг</p> <p>8. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ улс орнуудын нэгтгэл, ангиудын зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны боломж, байлдаан явуулах үндэс</p>	<p>тооцоо, өгөгдөхүүн бэлтгэх аргачлал</p> <p>4. Тагнуулын байлдааны баримт бичгүүдийг боловсруулах аргачлал</p> <p>5. МББр-ын ерөнхий цэргийн тагнуулын хүч хэрэгслийн боломжийг дээшлүүлэх арга зам.</p> <p>Тооцоо</p> <p>6. Төрөл бүрийн хийцийг тэслэх, тэсэлгээний тооцоо хийх</p> <p>7. Тагнуул-хорлон сүйтгэх ажиллагааг зохион байгуулах үндэс</p>	
б. Ур чадварын түвшин		
<p>1. Мбр хүртэлх хүч хэрэгсэлтэй тагнуулын салбар, бүлгийг ажиллагааг төлөвлөх, зохион байгуулж, удирдах</p> <p>2. БТСМ, ЯЦБМ, мотоцикл жолоодох</p> <p>3. Тагнуулын мэдээг сонсголоор хүлээн авч 15-20 бүлэг мэдээг шифрлэн холбооны хэрэгслээр дамжуулах</p> <p>4. Холын зай, өнцөг хэмжих, чиглэл тодорхойлох</p> <p>5. Азимутаар хөдөлгөөн үйлдэх</p> <p>ПАБ-2 Буссоль ашиглан тооцоо хийж чаддаг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Мббр-ын тагнуулын хүч хэрэгслийн ажиллагааг төлөвлөх, зохион байгуулж, удирдах</p> <p>2. Байлдааны талбар дахь тагнуулын байгууллагуудын ажиллагааг зохион байгуулах</p> <p>3. Төрөл бүрийн хийцийг тэслэх, тэсэлгээний тооцоо хийх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Газрын навигацын аппарат ТНА-3-ыг ажилд бэлтгэх, ажиллуулах</p> <p>2. Тагнуулын бэлтгэл сургалтыг төлөвлөх, зохион байгуулах</p>

Б. Тусгай томилолтын тагнуул

III зэрэг	II зэрэг	I зэрэг
1. Стратеги-тактик, команд-штабын мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Ерөнхий цэргийн байлдааны ажиллагааны үндэс</p> <p>2. Цэргийн тагнуулын үндэс, тагнуулын төрөл, тавигдах шаардлага</p> <p>3. Тагнуул зохион байгуулалт, төлөвлөлтийн үндэс</p> <p>4. Тагнуул явуулах үндсэн аргууд</p> <p>5. Тагнуулын мэдээ сэлтийг цуглуулан боловсруулж илтгэх журам</p> <p>6. Тагнуулын байлдааны баримт бичгүүдийн агуулга, боловсруулах журам</p> <p>7. 6. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын армийн бүтэц, зохион байгуулалт, үндсэн төрлийн зэвсэглэл, байлдааны боломж, тэдний цэргийн стратеги, оператив-тактикийн ажиллагааны үндэс</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчний тусгай радио холбооны заавар</p> <p>2. Шүхэр десантын албаны заавар</p> <p>3. Цэргийн тагнуулын байгууллагаас мэдээ, материал боловсруулах журам</p> <p>4. Цэргийн удирдлагын онолын үндэс</p> <p>5. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын зэвсэгт хүчний оператив-тактикийн ажиллагааны үндэст гарч буй өөрчлөлтүүд</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Зэвсэгт түрэмгийллийн тухай ойлголт, түүний ангилал</p> <p>2. Тусгай томилолтын тагнуулын бүлгийн байлдааны боломжийг дээшлүүлэх арга зам</p> <p>3. Тусгай томилолтын тагнуулын бүлгүүдийн орших, амьдрах чадварыг дээшлүүлэх арга зам</p> <p>4. Цэрэг газар зүйн үнэлгээ хийх аргачлал</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Зэвсэгт хүчин, цэргийн бүлэглэл, нэгтгэл, ангийн удирдлагыг тагнуулын мэдээ, мэдээллээр тасралтгүй хангах</p> <p>2. Зураг дээр болон газар орон дээр богино хугацаанд</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Төрөл бүрийн цагийн байдал дээр оператив</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Цэрэг-стратегийн болон оператив-</p>

<p>цагийн байдлыг тогтоон тагнуулын хүч хэрэгслийг ашиглах санал, дүгнэлт гаргах</p> <p>3. Төрөл бүрийн тактикийн болон тагнуулын тооцоо, өгөгдөхүүн бэлтгэх</p> <p>4. Цэргийн тагнуулыг төлөвлөх, зохион байгуулж удирдах</p>	<p>тактикийн төрөл бүрийн тооцоо хийх</p> <p>2. Тусгай томилолтын тагнуулын бүлгийн боломжийг тодорхойлох тооцоо бодох</p>	<p>тактикийн түвшинд дүгнэлт хийх</p> <p>2. Тусгай томилолтын тагнуулын хүч хэрэгсэлтэй явуулах тусгай тактикийн хээрийн сургуулийн бодлого, төлөвлөгөө боловсруулж, холбогдох тооцоо өгөгдөхүүнийг бэлтгэх</p>
--	--	---

2. Командын мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдааны үндэс</p> <p>2. Цэргийн тагнуулын үндэс, тагнуулын төрөл, тавигдах шаардлага</p> <p>3. Тагнуул зохион байгуулалт, төлөвлөлтийн үндэс</p> <p>4. Тагнуулын объектын тагнагдах шинж тэмдэг</p> <p>5. Тагнуул явуулах үндсэн аргууд</p> <p>6. Салбарын тагнуулын зэвсэг, байлдааны техник, табель хэрэгслийн үүрэг зориулалт, хүчин чадал, байлдааны боломж, ашиглалт, хадгалалт, засвар үйлчилгээний горим</p> <p>7. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ улс орнуудын армийн нэгтгэл, ангиудын зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны боломж, оператив, тактикийн ажиллагааны үндэс</p> <p>8. Радио тагнуулын тэмдэгтүүдийг бүрэн таньдаг нэвтрүүлэх, хүлээн авах</p> <p>9. Тусгай радио холбооны онцлог холбоо барих журам</p> <p>10. Тагнуулын байлдааны баримт бичгүүдийн агуулга, боловсруулах журам</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Дайсны ар талд явуулах тусгай томилолтын тагнуулын бүлгийн ажиллагаа</p> <p>2. Цэргийн өнгөлөн далдлалт</p> <p>3. Төрөл бүрийн аргаар тэсэлгээний ажил хийх, тэсэлгээний ажлын хэрэгслүүд</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>2. Тусгай радио хопбооны заавар, түүнийг зохион байгуулах онцлог</p> <p>3. Шүхэр десантын албаны заавар, нислэг буултын үеийн албан тушаалтны үүрэг</p>
---	---	---

б. Ур чадварын түвшин

<p>1. Тактикийн шуурхай дадлага бодох</p> <p>2. БТСМ, ЯЦБМ, мотоцикл жолоодох, ердийн хөсөг ашиглах чадвартай байх</p> <p>3. Нэг минутанд 8 бүлэг үсэг мэдээ, 10 бүлэг тоон мэдээг хүлээн авах, 10 бүлэг үсэг мэдээ. 8 бүлэг тоон мэдээг нэвтрүүлэх чадвартай байх</p> <p>4. Холын зай, өнцөг хэмжих, чиглэл тодорхойлох</p> <p>5. Азимутаар хөдөлгөөн үйлдэхэд шаардлагатай өгөгдөхүүнийг бэлтгэх</p> <p>6. Өдөр, шөнө, модонд, усны мандалд шүхрээр бууж чаддаг</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Төрөл бүрийн тактикийн тооцоо хийх</p> <p>2. ПАБ-2 Бүссоль ашиглан тооцоо хийж чаддаг</p> <p>3. Нэг минутанд 10 бүлэг үсэг, 12 бүлэг тоон мэдээг хүлээн авах, 12 бүлэг үсэг, 10 бүлэг тоон мэдээг нэвтрүүлэх чадвартай байх</p> <p>4. Төрөл бүрийн хийцийг тэслэх тэсэлгээний ажлын тооцоо</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тагнуулын мэдээг цуглуулан боловсруулж, оператив-тактикийн түвшинд дүгнэлт хийх</p> <p>2. Газрын навигацын аппарат ТНА-3-ыг ажилд бэлтгэх, ажиллуулах</p> <p>3. Нэг минутанд 12 бүлэг үсэг, 14 бүлэг тоон мэдээг хүлээн авах, 14 бүлэг үсэг, 12 бүлэг тоон мэдээг нэвтрүүлэх чадвартай байх</p>
---	--	--

3. Тагнуулын мэргэжилтэн

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдааны үндэс</p> <p>2. Цэргийн тагнуулын үндэс</p> <p>3. Тагнуулын объектуудын тагнагдах шинж тэмдэг, тагнуул</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Дайсны гүн ар талд тусгай томилолтын</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тусгай томилолтын тагнуулын бүлгийн</p>
--	--	--

<p>явуулах аргууд</p> <p>4. Тусгай радио холбооны онцлог, холбоо барих журам</p> <p>5. Салбарын зэвсэглэлд байгаа бүх төрлийн шүхэр, шүхрийн техник хэрэгсэл, зэвсэг, байлдааны техник, табель хэрэгслийн үүрэг зориулалт, ТТӨ, байлдааны боломж, ажиллах зарчим</p> <p>6. Радио телеграфын тэмдэгтүүд, тэдгээрийг нэвтрүүлэх, хүлээн авах журам</p> <p>7. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын бүтэц. зохион байгуулалт, зэвсэглэл, тактикийн ажиллагааны үндэс</p>	<p>тагнуулын бүлгийн ажиллагаа</p> <p>2. Тагнуулын бүлэг /байгууллага/-ийн гишүүдийн үүрэг</p> <p>3. Төрөл бүрийн аргаар тэсэлгээний ажил хийх, тэсэлгээний ажлын хэрэгслүүд</p>	<p>амьдрах, бат орших чадвар, түүний үүрэг, байлдааны боломж</p> <p>2. Газрын навигацын аппарат ТНА-3-ыг ажилд бэлтгэх, ажиллуулах үндэс</p>
--	--	--

б. Ур чадварын түвшин

<p>1. Салбарын зэвсэглэлд байгаа техник хэрэгсэл дээр хийх нэг бүрийн нормативуудыг сайнаас онц үнэлэлттэй биелүүлдэг байх</p> <p>2. Ойрын тулаан, гардан байлдааны арга, техник</p> <p>3. Газар орон дээр баримжаалах</p> <p>4. Буудлагын курст заагдсан дасгалуудыг сайнаас онц дүнтэй боловсруулдаг байх</p> <p>5. Өдөр, шөнийн болон усны мандал дээр, ой модонд зэвсэг хэрэглэлтэйгээр шүхрээр буух чадвартай байх</p> <p>6. Нэг минутанд 8 бүлэг үсэг мэдээ, 10 бүлэг тоон мэдээг хүлээн авах, 10 бүлэг үсэг мэдээ. 8 бүлэг тоон мэдээг нэвтрүүлэх чадвартай байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тагнуулын бүлгийн аль нэг гишүүнийг орлон ажиллах</p> <p>2. Төрөл бүрийн аргаар холын зай, өнцөг хэмжих, чиглэл тодорхойлох</p> <p>3. Азимутаар хөдөлгөөн үйлдэхэд шаардлагатай мэдээ бэлтгэх</p> <p>4. Ачааны шүхэр ПДММ-ийг эвхэж түүнд ачааг бэхэлж чаддаг байх</p> <p>5. Нэг минутанд 10 бүлэг үсгэн, 12 бүлэг тоон мэдээг хүлээн авах. 12 бүлэг үсэг, 10 бүлэг тоон мэдээг нэвтрүүлэх чадвартай байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тагнуулын бүлгийн дарга, бусад гишүүдийг орлон ажиллах</p> <p>2. Газрын навигацын аппарат ТНА-3-ыг ажилд бэлтгэх, ажиллуулах</p> <p>3. Байр зүйн зураг унших, түүнд цель оруулж, солбилцлыг тодорхойлох</p> <p>4. Төрөл бүрийн хийцийг тэслэх тэсэлгээний ажлын тооцоо</p> <p>5. Нэг минутанд 10 бүлэг үсэг, 12 бүлэг тоон мэдээг хүлээн авах, 12 бүлэг үсэг, 10 бүлэг тоон мэдээг нэвтрүүлэх чадвартай байх</p>
---	---	---

В. Шүхрийн мэргэжлээр

III зэрэг	II зэрэг	I зэрэг
1. Шүхрийн зааварлагч		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Шүхрийн зааварлагчийн дамжаанд суралцаж “Сайн”-аас доошгүй дүнтэй төгссөн</p> <p>2. Шүхэр десантын болон нислэг буултын аюулгүй ажиллагааны заавар</p> <p>3. Шүхэр, шүхэр десантын техник хэрэгслийг ашиглах, хадгалах</p> <p>4. Шүхэр, шүхрийн техник хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх онолын мэдлэгтэй байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тусгай үүргийн буултуудыг үйлдэх онцлогыг мэддэг /шөнө, усанд, ой модонд, хэт өндөр, хэт нам өндөр, хурдтай онгоцны/</p> <p>2. Зэвсэг, галт хэрэглэл, холбооны хэрэгсэлтэйгээр шүхрээр буух онцлог</p> <p>3. Турших шүхрийн тооцоолол хийх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Нислэг буултыг зохион байгуулж явуулах журам</p> <p>2. Бие бүрэлдэхүүнийг шүхрээр буулгах нөхцөл</p> <p>3. Шүхэрчид болон ачааг онгоцноос тооцоолон гаргах</p> <p>4. Нислэг буултын үед онгоцыг газраас удирдах, онгоцтой холбоо барих журам</p>

б. Ур чадварын түвшин		
<p>1. Шүхрээр 100-аас доошгүй удаа буусан</p> <p>2. Анги, салбарт байгаа бүх төрлийн шүхрийг эвхэж чаддаг</p> <p>3. Шүхэр эвхэлтийн үе шатуудад үзлэг хийж гарсан алдаа, зөрчлийг арилгаж чаддаг</p> <p>4. Тусгай үүргийн буултуудыг гүйцэтгэх ур чадвар эзэмшсэн, бүлгээр болон цаг агаарын хүндрүүлсэн ямар ч нөхцөлд шүхрээр буух ур чадвар эзэмшсэн байх.</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Шүхрээр 200-гаас доошгүй удаа буусан</p> <p>2. Ачааны шүхрийг эвхэн ПДММ-47-д бэхэлж ачаа буулгаж чаддаг байх</p> <p>3. Төхөөрөмжлөгдсөн станц буулгагч /ГК-30/-тай ба зэвсэгтэй 5-аас доошгүй удаагийн буулт хийсэн байх</p> <p>4. Шүхрийн автомат задлагчид үзлэг хийж шүхэрт төхөөрөмжлөн бэхэлдэг байх</p> <p>5. Тусгай үүргийн буултуудыг 3-аас доошгүй удаа гүйцэтгэсэн байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Шүхрээр 300-аас доошгүй удаа буусан байх</p> <p>2. Ачааны шүхрийг бие даан эвхэж, ачааг онгоцноос тооцоолон хаяж заасан районд буулгах</p> <p>3. Бүх төрлийн онгоцноос шүхэрчдийг тооцоолон гаргах</p> <p>4. Шүхэр болон автомат задлагчид техник үйлчилгээ хийх, эвдрэлийг тодорхойлж засах</p> <p>5. Тусгай үүргийн буултуудыг 6-аас доошгүй удаа гүйцэтгэсэн байх</p> <p>6. 1600 м-ээс дээш өндрөөс 15 секундээс багагүй хугацаанд чөлөөт уналт хийх</p>

2. Шүхэрчин

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Шүхэр десантын болон нислэг буултын аюулгүй ажиллагааны заавар</p> <p>2. Шүхэр, шүхэр десантын техник хэрэгслийг ашиглах, хадгалах</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1.Тусгай үүргийн буултуудыг үйлдэх онцлогыг мэддэг /шөнө, усанд, ой модонд, хэт өндөр, хэт нам өндөр, хурдтай онгоцны/</p> <p>2. Зэвсэг, галт хэрэглэл, холбооны хэрэгсэлтэйгээр шүхрээр буух онцлог</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1.Шүхэр, шүхрийн техник хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх</p> <p>2. Турших шүхрийг тооцоолон хийх</p> <p>3.Ангид ашиглагдаж буй бүх төрлийн шүхрийн үүрэг, зориулалт, ТТӨ-ийг мэддэг</p>
--	---	--

б. Ур чадварын түвшин

<p>1. Шүхрийн дамжаанд суралцаж “Сайн”-аас дээш дүнтэй төгсөж, шүхрээр 60-аас доошгүй удаа буусан</p> <p>2. Өөрийн хэрэглэдэг төрлийн шүхрийг бүрэн эзэмшсэн</p> <p>3. Шүхэр эвхэлтийн үе шатуудыг мэддэг</p> <p>4. Бүлгээр болон цаг агаарын хүндрүүлсэн ямар ч нөхцөлд шүхрээр буух ур чадвар эзэмшсэн байх.</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Шүхрээр 100-гаас доошгүй удаа буусан</p> <p>2.Төхөөрөмжлөгдсөн станц буулгагч /ГК-30/-тай ба зэвсэгтэй 2-оос доошгүй удаагийн буулт хийсэн байх</p> <p>3. Зэвсэглэлд байгаа 2 төрлийн /дугуй, дөрвөлжин дэлбээтэй/ шүхрийг бүрэн эзэмшсэн</p> <p>4. Тусгай үүргийн буултуудыг 2-оос доошгүй удаа гүйцэтгэсэн байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Шүхрээр 150-аас доошгүй удаа буусан</p> <p>2. Ачааны шүхрийг эвхэн ПДММ-47-д бэхэлж ачаа буулгаж чаддаг байх</p> <p>3. Шүхрийн автомат задлагчид үзлэг хийж шүхэрт төхөөрөмжлөн бэхэлдэг байх</p> <p>4. Зэвсэглэлд байгаа бүх төрлийн шүхрээр буух чадвартай</p> <p>5. Тусгай үүргийн буултуудыг 4-өөс доошгүй удаа гүйцэтгэсэн байх</p>
--	---	---

Г. Радиотагнуулын мэргэжлээр

1. Командын мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдааны болон тагнуул зохион байгуулах үндэс</p> <p>2. Бүх төрлийн байлдаанд радио тагнуулыг төлөвлөх. зохион байгуулах үндэс</p> <p>3. Агаар мандлын бүтэц, радио долгионы тархалтын үндэс</p> <p>4. Радиодолгионы тархалт, богино болон хэт богино долгионы тархалтын онцлог</p> <p>5. Радио тагнуулын дүрэм, заавар</p> <p>6. Бүх төрлийн байлдаанд РПР болон хөдөлгөөнт бүлгийн радио тагнуул зохион байгуулах, удирдах онолын мэдлэг эзэмшсэн байх</p> <p>7. Тагнагдаж байгаа эх булгийн тагнагдах шинж тэмдгүүд, ажиллагааны онцлогийг судалсан</p> <p>8. Олзворлосон мэдээ материалд боловсруулалт хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх</p> <p>9. Радио тагнуулыг нутгийн гүнээс явуулах РПР-ын үүрэг, бусад салбаруудтай харилцан ажиллагааг зохион байгуулах арга ажиллагаа</p> <p>10. Анги, салбарт байгаа тусгай зориулалтын техник хэрэгслийн ТТӨ, байлдааны боломж, ашиглалтын үндэс</p> <p>11. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын нэгтгэл ангиудын бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны боломж</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Радио тагнуулыг зохион байгуулах үед гарч буй шинэлэг зүйлүүд</p> <p>2. Радио тагнуулыг зохион байгуулах ажиллагааны боломжийг дээшлүүлэх арга зам</p> <p>3. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын нэгтгэл, ангиудын оператив тактикийн ажиллагаанд гарч буй өөрчлөлтүүд</p> <p>4. Радио тагнуулыг зохион байгуулах тооцоо хийх мэдлэг эзэмшсэн байх</p> <p>5. РПР болон хөдөлгөөнт бүлгийн бие даасан радио тагнуулыг зохион байгуулах удирдах ажиллагааг эзэмшсэн байх</p> <p>6. Техник хэрэгсэлд сэргээн сайжруулах үйлчилгээ хийх мэдлэгтэй байх</p> <p>7. Тайван болон байлдааны цагт цэргийн удирдлагыг хэрэгжүүлэх, штабын албыг зохион байгуулах мэдлэгтэй байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Радио тагнуулын мэдээ, мэдээллээр дээд удирдлагыг хангах арга зам</p> <p>2. Радио тагнуулын төлөвлөлт, удирдлага, бүх талын хангалт</p> <p>3. Бүс нутгийн болон орон нутгийн зэвсэгт мөргөлдөөнд радио тагнуулыг зохион байгуулах арга, ажиллагааг судалсан байх</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Радио тагнуулын байлдааны баримт бичиг боловсруулах</p> <p>2. РПР болон хөдөлгөөнт бүлэгтэй явуулах тусгай тактикийн хээрийн сургуулийг төлөвлөх, удирдах</p> <p>3. Нэг талын радио телеграфчид үсэг мэдээг 60, тоон мэдээг 60, холимог мэдээг 60 тэмдэгт минутанд сонсголоор хүлээж авах</p> <p>4. Хоёр талын радиотелеграфчид: үсэг мэдээг 60, тоон мэдээг 60 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авч, үсэг мэдээг 60, тоон мэдээг 60 тэмдэгт минутанд түлхүүрээр нэвтрүүлэх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Радио тагнуулыг зохион байгуулах</p> <p>2. Ангийн зэвсэглэлд байгаа тусгай техник хэрэгслийг төрөл бүрийн горимд бүрэн хүчин чадлаар нь ашиглах</p> <p>3. Нэг талын радио телеграфчид үсэг мэдээг 80, тоон мэдээг 85, холимог мэдээг 75 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авах</p> <p>4. Хоёр талын радио телеграфчид үсэг мэдээг 70, тоон мэдээг 70 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авч, үсэг мэдээг 70, тоон мэдээг 70 тэмдэгт минутанд түлхүүрээр нэвтрүүлэх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Хөрш зэргэлдээ орнуудын оперативын цагийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч чаддаг байх</p> <p>2. Нэг талын радио телеграфчид үсэг мэдээг 90, тоон мэдээг 95, холимог мэдээг 85 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авах.</p> <p>3. Хоёр талын радио телеграфчид үсэг мэдээг 80, тоон мэдээг 80 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авч, үсэг мэдээг 80 ,тоон мэдээг 80 тэмдэгт минутанд түлхүүрээр нэвтрүүлэх</p>
3. Радио тагнуулын мэргэжилтэн		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдааны болон тагнуулын</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан</p>

<p>үндэс</p> <ol style="list-style-type: none"> 2. Радио тагнуул явуулах үндэс 3. Тагнагдаж буй эх булгийн радио солилцооны онцлог, кодын товчлолыг мэддэг байх 4. Радио мэдээний бүтэц, эх булгийн тагнагдах шинж тэмдэг, яаралтай илтгэх мэдээг мэддэг байх 5. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын батальон хуртэлх анги, салбаруудын бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, тактикийн ажиллагаа 6. Анги, салбарын зэвсэглэлд байгаа техник хэрэгслийн ТТӨ, байлдааны боломж, ашиглалтын онцлог, техник хэрэгсэл дээр ажиллах аюулгүйн арга хэмжээг судалсан байх 7. Радио тагнуулын техник хэрэгсэл дээр. Засвар, үйлчилгээ хийх үндэс 	<p>байхаас гадна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Өөрийн үндсэн постын үүргээс гадна өөр 1 постон дээр ажиллах онолын мэдлэг эзэмшсэн байх 2. Өөрийн албан тушаалаас нэг шат дээгүүр албан тушаалтны үүргийг судалсан байх 	<p>байхаас гадна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байлдааны постуудын бүх үүргийг судалсан байх 2. Оперативын жижүүрийн үүргийг судалсан байх
---	--	---

б. Ур чадварын түвшин

<ol style="list-style-type: none"> 1. Анги, салбарын зэвсэглэлд байгаа техник хэрэгслийг төрөл бүрийн горимд тохируулж, ажиллах 2. Олзворлосон мэдээ материалд анхан шатны боловсруулалт хийж, постын бичиг баримтыг зөв хөтлөх 3. Техник хэрэгсэл дээр сэргээн сайжруулах үйлчилгээ хийх 4. Зэвсэглэлд байгаа техник хэрэгсэл дээр хийх нормативыг биелүүлэх <ol style="list-style-type: none"> a. Нэг талын радио телеграфчид үсэг мэдээг 60, тоон мэдээг 60, холимог мэдээг 60 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авах b. Хоёр талын радио телеграфчид үсэг мэдээг 60, тоон мэдээг 60 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авч, үсэг мэдээг 60, тоон мэдээг 60 тэмдэгт минутанд түлхүүрээр нэвтрүүлэх 	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байлдааны постонд бие биенээ орлон ажиллах дадлага эзэмшсэн байх 2. Шинээр радио телеграфчний мэргэжил эзэмшигчдэд дадлага олгох, заах аргын дадлага эзэмшсэн байх 3. Нэг талын радио телеграфчид үсэг мэдээг 85, тоон мэдээг 95, холимог мэдээг 80 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авах 4. Хоёр талын радио телеграфчид үсэг мэдээг 80, тоон мэдээг 80 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авч, үсэг мэдээг 80, тосн мэдээг 80 тэмдэгт минутанд түлхүүрээр нэвтрүүлэх 	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Байлдааны бүх постонд ажиллах дадлага эзэмшсэн байх 2. Оперативын жижүүрийг орлон ажиллах дадлага эзэмшсэн байх 3. Нэг талын радио телеграфчид үсэг мэдээг 95, тоон мэдээг 105, холимог мэдээг 90 тэмдэгт минутанд хүлээн авах 4. Хоёр талын радио телеграфчид үсэг мэдээг 90, тоон мэдээг 90 тэмдэгт минутанд сонсголоор хүлээн авч үсэг мэдээг 90, тоон мэдээг 90 тэмдэгт минутанд түлхүүрээр нэвтрүүлэх
---	--	---

Д. Тусгай радио холбооны мэргэжлээр

1. Стратеги-тактик, команд штабын мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
<ol style="list-style-type: none"> 1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдаан болон тагнуул зохион байгуулах үндэс 2. Тусгай радио холбооны дүрэм, заавар 3. Төрөл бүрийн байлдаанд тусгай радио холбоог төлөвлөх, зохион байгуулах. удирдах арга ажиллагаа 4. Зэвсэгт хүчний радио холбооны заавар 5. Агаар мандлын бүтэц, радио долгионы тархалтын онцлог 6. Сарын болон удаан хугацааны урьдчилсан мэдээг 	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Тусгай радио холбоог зохион байгуулахад гарч буй шинэлэг аргууд 2. ТРХ-ны техник хэрэгсэлд хийх урьдчилсан болон хэвшүүлэх ажил 3. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын нэгтгэл, ангиудын оператив-тактикийн 	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Бүх төрлийн байлдааны ажиллагаанд тусгай радио холбоог зохион байгуулах боломжийг дээшлүүлэх арга зам 2. Бүс нутгийн болон орон нутгийн зэвсэгт мөргөлдөөнд тусгай радио холбоог зохион байгуулж буй онцлог, сургамж

<p>ашиглан радио үелзлийг сонгох</p> <p>7. Богино болон хэт богино долгионы тархалтын онцлог</p> <p>8. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын нэгтгэл, ангиудын бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны боломж</p> <p>9. Зэвсэглэлд байгаа радио, тусгай радио холбооны техник хэрэгслийн ТТӨ, байлдааны боломж, техник үйлчилгээний үечлэл</p>	<p>ажиллагаанд гарч буй өөрчлөлтүүд</p>	<p>3. Сансрын холбооны онолын үндэс</p>
---	---	---

б. Ур чадварын түвшин

<p>1. Тусгай радио холбооны үндэс, төлөвлөлт, зохион байгуулалт</p> <p>2. Тусгай радио холбооны байлдааны баримт бичгүүдийн агуулга, боловсруулах журам</p> <p>3. Зэвсэглэлд байгаа тусгай радио холбооны техник хэрэгслийн ашиглалт, зохион байгуулалт</p> <p>4. Тоон мэдээг минутанд 12 бүлэг, үсэг мэдээг минутанд 12 бүлгийг сонсголоор хүлээн авч, тоон ба үсэг мэдээг 12 бүлгийн хурдаар түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>5. РЭТ-ийн саатуулга хийсэн тохиолдолд ажиллах онцлог</p> <p>6. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж 16 минутанд радио чигт 80 бүлгийн солилцоо хийх /тус бүр 10 -20 бүлэгтэй 3-4 тоон мэдээг нэвтрүүлэх, хүлээн авах/</p> <p>7. Тусгай радио холбооны нормативуудыг гүйцэтгэх арга, дэс дараалал, онцлог</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тусгай радио холбоог зохион байгуулах, тооцоо өгөгдөхүүн боловсруулах</p> <p>2. Тоон мэдээг минутанд 14 бүлэг, үсэг мэдээг минутанд 14 бүлгийг сонсголоор хүлээж авч, тоон ба үсэг мэдээг 14 бүлгийн хурдаар түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>3. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж 40 минутанд радио чигт 90 бүлгийн солилцоо хийх /тус бүр 15-25 бүлэгтэй 4-5 бүлэгтэй мэдээг нэвтрүүлэн, мөн тийм мэдээг харилцагчаас хүлээн авах/</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тусгай радио холбоог зохион байгуулах, оператив-тактикийн хэд хэдэн хувилбар гаргах, ашигтайг нь сонгох</p> <p>2. Тоон мэдээг минутанд 16 бүлэг, үсэг мэдээг минутанд 16 бүлгийг сонсголоор хүлээн авч, тоон ба үсэг мэдээг 16 бүлгийн хурдаар түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>3. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж 35 минутанд радио чигт 100 бүлгийн солилцоо хийх /тус бүр 5-6 бүлэгтэй 5-6 бүлэгтэй мэдээг нэвтрүүлэх, хүлээн авах/</p>
--	--	---

2. Командын мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдаан болон тагнуул зохион байгуулах үндэс</p> <p>2. ТРХ-ны заавар дүрэм</p> <p>3. Тусгай радио холбоог төлөвлөх, зохион байгуулах үндэс</p> <p>4. Агаар мандлын бүтэц, түүний радио долгионд үзүүлэх нөлөөлөл</p> <p>5. Тусгай бопон ТТБ-тэй тусгай радио холбоог зохион байгуулах үндэс</p> <p>6. Богино болон хэт богино долгионы тархалтын онцлог</p> <p>7. Анги. салбарын техник хэрэгслийн ТТӨ, байлдааны боломж, ашиглалт, хадгалалтын онцлог</p> <p>8. РЭТ-ийн саатуулга хийсэн нөхцөлд холбоонд орох арга зам</p> <p>9. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын нэгтгэл, ангиудын бүтэц зохион байгуулалт, зэвсэглэл, байлдааны боломж</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тусгай радио холбоог зохион байгуулах шинэлэг арга, хэпбэр</p> <p>2. Техник хэрэгсэлд хийх сэргээн сайжруулах үйлчилгээ</p> <p>3. Тусгай радио холбооны техник, хэрэгслийн ашиглалт</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Цагийн байдлын ямар ч нөхцөлд тусгай радио холбоог зохион байгуулах, холбоонд орох арга зам</p> <p>2. Бүс нутгийн болон орон нутгийн зэвсэгт мөргөлдөөнд тусгай радио холбоог зохион байгуулж туршлага, сургамж</p>
--	---	--

б. Ур чадварын түвшин		
<p>1. ОТРХЗ болон ТТБ-тэй явуулах тусгай тактикийн хээрийн сургуулийн төлөвлөлт</p> <p>2. ТРХ-г төлөвлөх, зохион байгуулах тухай байлдааны баримт бичиг боловсруулах</p> <p>3. ТРХ-ны зааврын дагуу радио солилцоог тогтоосон хугацаанд хийх</p> <p>4. Тоон мэдээг минутанд 12 бүлэг, үсэг мэдээг минутанд 12 бүлэг сонсголоор хүлээн авч, тоон ба үсэг мэдээг 12 бүлгийн хурдаар түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>5. Дайснаас РЭТ-ийн саатуулга хийсэн тохиолдолд түүнээс гарч үелзлийг зөв сонгон авах</p> <p>6. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж 45 минутанд радио чигт 200 бүлгийн солилцоо хийх /тус бүр 50 бүлэгтэй нэг нэг тоон ба үсэг мэдээг нэвтрүүлэн мөн тийм мэдээг харилцагчаас хүлээн авах/</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тусгай радио холбооны техник хэрэгслүүдийн бүх төрлийн зай хураагууруудыг хээрийн нөхцөлд цэнэглэх</p> <p>2. Тоон мэдээг минутанд 14 бүлэг, үсэг мэдээг минутанд 14 бүлэг сонсголоор хүлээн авч, тоон ба үсэг мэдээг 14 бүлгийн хурдаар түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>3. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж 40 минутанд радио чигт 200 бүлгийн солилцоо хийх /тус бүр 50 бүлэгтэй нэг, нэг тоон ба үсэг мэдээг нэвтрүүлэн, мөн тийм мэдээг харилцагчаас хүлээн авах/</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тусгай радио холбооны техник хэрэгслүүдийг хээрийн нөхцөлд дэлгэх</p> <p>2. Тоон мэдээг минутанд 16 бүлэг, үсэг мэдээг минутанд 16 бүлэг сонсголоор хүлээн авч, тоон ба үсэг мэдээг 16 бүлгийн хурдаар түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>3. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж 35 минутанд радио чигт 200 бүлгийн солилцоо хийх /тус бүр 50 бүлэгтэй нэг, нэг тоон ба үсэг мэдээг нэвтрүүлэн, мөн тийм мэдээг харилцагчаас хүлээн авах/</p>
3. Тусгай радио холбооны мэргэжилтэн		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Орчин үеийн ерөнхий цэргийн байлдааны үндэс</p> <p>2. Тусгай радио холбооны заавар, дүрэм</p> <p>3. Радио солилцооны онцлог, журам</p> <p>4. Ангийн зэвсэглэлд байгаа радио, тусгай радио холбооны техник хэрэгслийн ТТӨ, ашиглалт</p> <p>5. ТРХ-ны техник хэрэгслүүдэд ашиглагдах нуувч, өнгөлөн далдлалтын онцлог, арга</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Өөрийн гуйцэтгэх үүргээс гадна нэг шат дээгуур албан тушаалын үүргийг судалсан байх</p> <p>2. Шинээр радио телеграфчины мэргэжил эзэмшигчдэд дадлага олгох, заах аргын дадлага эзэмшсэн байх</p> <p>3. Газар орноо судлах үелзлийн царааны онцлог</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Бүх радио телеграфчдын үүргийг судалсан байх</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Салбарын зэвсэглэлд байгаа радио, тусгай радио холбооны техник хэрэгсэл дээр хийх норматив</p> <p>2. ТРХ-ны бүх төрлийн техник хэрэгслийг хээрийн нөхцөлд дэлгэн байгуулах газар орон, ашиглах антенны төхөөрөмжийг сонгох</p> <p>3. Дайснаас РЭТ-ийн саатуулга хийсэн тохиолдолд түүнээс гарч холбоонд орох</p> <p>4. Тоон мэдээг минутанд 14 бүлэг, үсэг мэдээг минутанд 14 бүлэг сонсголоор хүлээн авч, тоон ба үсэг мэдээг 12 бүлгийн хурдаар алдаагүй цэвэр түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>5. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж 40 минутанд радио чигт 200 бүлгийн солилцоо хийх, /тус бүр 50 бүлэгтэй нэг, нэг тоон ба үсэг мэдээг нэвтрүүлэх, хүлээн авах/</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. ТРХ-ны техник хэрэгсэлд ашиглагдаж буй зай хураагууруудыг хээрийн нөхцөлд цэнэглэх</p> <p>2. Тоон мэдээг минутанд 16 бүлэг, үсэг мэдээг минутанд 16 бүлэг сонсголоор хүлээн авч, тоон ба үсэг мэдээг минутанд 14 бүлгийн хурдаар түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>3. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж, 35 минутанд радио чигт 200 бүлгийн солилцоо хийх /тус бүр 50 бүлэгтэй нэг, нэг тоон ба үсэг мэдээг нэвтрүүлэх, хүлээн авах/</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Өөрийн албан тушаалаас нэг шат дээгүүр албан тушаалтныг орлон ажиллах</p> <p>2. Тоон мэдээг минутанд 18 бүлэг, үсэг мэдээг минутанд 18 бүлэг сонсголоор хүлээн авч, тоон ба үсэг мэдээг 16 бүлгийн хурдаар түлхүүрээр нэвтрүүлэх</p> <p>3. Хээрийн нөхцөлд ТРХ-ны зааврыг баримтлан холбоонд орж 30 минутанд радио чигт 200 бүлгийн солилцоо хийх /тус бүр 50 бүлэгтэй нэг, нэг тоон ба үсэг мэдээг нэвтрүүлэх, хүлээн авах/ байх</p>

Е. Орчуулагч мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
1. Батлан хамгаалах эрх зүй, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт 2. Цэргийн нэр, томъёо, үг хэллэг 3. Гадаад хэлний орчуулга, найруулга зүй 4. Бүс нутгийн болон хөрш зэргэлдээ орнуудын тактикийн анги, салбаруудын бүтэц, зохион байгуулалт, байлдааны боломж, тактикийн ажиллагааны үндэс	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Орчуулагчийн ёс зүй, харилцааны онцлог 2. Гадаадын цэрэг, түүний удирдлага, зохион байгуулалт, эвсэглэл, байлдааны бэлтгэл, гадаад харилцаа, цэрэг-улс төр, цэрэг техник, эдийн засгийн мэргэжлийн үг хэллэг, нэр томъёо	II зэрэгт тавигдах шаардлагыг бүрэн байхаас гадна: 1. Орчуулагчаар 5-аас доошгүй жил ажилласан байх
б. Ур чадварын түвшин		
1. Гадаадын аль нэг хэлийг бүрэн эзэмшсэн байх 2. Аман болон бичгийн орчуулгыг чөлөөтэй хийх 3. Сонссон зүйлийнхээ 80 хувийг ойлгодог байх	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Гадаадын хоёроос доошгүй хэл мэддэг байх 2. Сонссон зүйлээ 100 хувь ойлгодог	II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Гадаадын гурваас доошгүй хэл мэддэг байх 2. Аман болон бичгийн шууд орчуулгыг хийх чадвартай байх

Гурав. Цэргийн холбооны мэргэжлээр

III зэрэг	II зэрэг	I зэрэг
1. Стратеги-тактик, команд-штабын мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
1. Зэвсэгт хүний нэгдэл, нэгтгэлийн үндсэн төрлийн байлдааны ажиллагааны үндэс 2. Холбооны мэргэжлийн чиглэлээр ЗХ-ний хэмжээнд мөрдөж буй дүрэм заавар, журмыг мэддэг байх 3. Төрөл бүрийн байлдаанд нэгдэл, нэгтгэлийн удирдлага, холбоо зохион байгуулах арга зам 4. Холбоо, мэдээллийн техник хэрэгслийн ажиллагааны зориулалт, боломж техникийн ашиглалт, хангалт, үйлчилгээг зохион байгуулах журам 5. Холбоог зохион байгуулах төлөвлөлтийн үндсэн бичиг баримтуудыг боловсруулах аргачлал 6. Нэгтгэл, ангийг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжих үеийн холбоо, удирдлагын зохион байгуулалт, бэлэн байдал 7. Гадаад орнуудын армийн нэгдэл, нэгтгэлийн зохион байгуулалт, эвсэглэл, байлдааны боломж, тактикийн ажиллагааны үндэс	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Дайн, байлдааны ажиллагааны үндэст гарч буй өөрчлөлт 2. Зэвсэгт хүчний дэлгэн байгуулалт, шилжүүлэн бүлэглэлтийн үеийн удирдлага, холбооны хангалт 3. Цэргийн алдагдсан удирдлагыг сэргээн босгох, байлдааны хохирлыг арилгах арга зам 4. Мэдээллийн тэмцэл, ҮОХЗ, НЦЗ, РЭТ-ийн хэрэгслүүдээс холбооны систем, бие бүрэлдэхүүн техник хэрэгслийг хамгаалах арга хэмжээ 5. Холбооны анги, салбаруудын бие дааж үүрэг гүйцэтгэх ажиллагааг зохион байгуулж явуулах онцлог 6. Холбооны техник хэрэгсэлд хийх сэргээн сайжруулах үйлчилгээний технологи	II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэх үеийн удирдлага, холбоо, мэдээллийн системийн хангалт 2. Бүс нутгийн болон орон нутгийн дайн байлдааны сургамж 3. Холбоо зохион байгуулах онолын хөгжлийн чиг хандлага 4. Холбооны системийн тогтвортой байдлыг хангах арга замууд 5. Зэвсэгт хүчин, ерөнхий зориулалтын цэрэг, төрлийн цэргийн командлал, нэгтгэл ангиудын байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжих үеийн холбоо, удирдлага

б. Ур чадварын түвшин		
<p>1. Холбоог төлөвлөх, зохион байгуулах, байлдааны ажиллагааны явцад холбоог тасралтгүй удирдах</p> <p>2. Байлдааны баримт бичгүүдийг тогтсон шаардлага стандартын дагуу боловсруулж чаддаг байх</p> <p>3. Анги, нэгтгэлийн холбооны даргын санал, тооцоо, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах</p> <p>4. Зэвсэгт хүчин, ерөнхий зориулалтын цэрэг, төрлийн цэргийн командлал, нэгтгэл ангиудын байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжих үеийн холбоо, удирдлагыг зохион байгуулах</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Холбооны аюулгүй байдал, цэргийн далдуур удирдлага, холбооны сахилгад илэрсэн зөрчлийг тодорхойлж чаддаг байх</p> <p>2. Холбооны техник хэрэгсэлд үзлэг шалгалт явуулж үнэлэлт дүгнэлт өгч чаддаг байх</p> <p>3. Нэгтгэл, анги, салбарын холбооны даргын санал, тооцоо, төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулах</p> <p>4. Зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэх үеийн удирдлага, холбоо, мэдээллийн системийн хангалтыг төлөвлөх, зохион байгуулах</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Цэргийн дээд удирдлагыг холбоогоор найдвартай хангах арга хэмжээг зохион байгуулах</p> <p>2. Радиорелейний мэргэжилтнүүд радиорелей, шим мандлын холбооны шугамын тооцоог хийх</p>
2. Холбооны инженерийн мэргэжлээр		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Холбоо, мэдээллийн техникийн онолын үндэс</p> <p>2. Техник үйлчилгээний төрөл, үечлэл ажлын багтаамж</p> <p>3. Техник хэрэгсэлд тохиолдох эвдрэл, гэмтлийн шалтгаан, илрүүлж, засварлах арга, технологи</p> <p>4. Холбооны аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ холбооны сахилга түүнд тавигдах шаардлага</p> <p>5. Холбооны техник хэрэгсэлд хийх сэргээн сайжруулах үйлчилгээ</p> <p>6. Холбооны засвар, ашиглалтын төлөвлөлт, тооцооны үндэс</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Техник ашиглалтын шаардлагууд</p> <p>2. Техникийн үндсэн параметруудийг хэмжих, тохируулга хийж зохих түвшинд хүргэх арга</p> <p>3. Хураангуй болон дэлгэрэнгүй бүдүүвчийн ажиллагаа, элементүүдийн онолын үндэс</p> <p>4. Холбооны чиглэлээр ЗХ-ний хэмжээнд мөрдөж буй дүрэм, заавар, журам</p> <p>5. Гадаад орнуудын армиудын ээвсэглэлд байгаа холбоо, мэдээллийн техник хэрэгсэл</p> <p>6. Холбоо, мэдээллийн техник хэрэгсэлд үзлэг шалгалт явуулах журам</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Техник хэрэгслийн хадгалалт, ашиглалтыг зохион байгуулах арга</p> <p>2. Хэмжилт тохируулгын зарчим, түүний үндэс</p> <p>3. ТҮ-нд зарцуулах материал, ШТМ тусгай шингэний орцын нормыг мэддэг байх</p> <p>4. Станц, аппаратуудын блокуудын ажиллагааны физикийн процесс</p> <p>5. Зарчмын бүдүүвчийн ажиллагааны зарчим</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Өөрийн мэргэжлийн чиглэлээр станц, аппарат хэрэгслийг тохируулж, шалгах</p> <p>2. Холбооны техник хэрэгслийн ашиглалт, үйлчилгээний болон шугам сувгуудыг хэмжих тэдгээрт хослол хийх нормативуудийг биелүүлэх</p> <p>3. Холбооны засвар, ашиглалтыг төлөвлөх</p> <p>4. Техник хэрэгсэлд тохиолдсон эвдрэл, гэмтлийн шалтгаан, илрүүлж, засварлах</p> <p>5. Техникийн үндсэн параметруудийг хэмжих, тохируулга хийх арга</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Дэлгэрэнгүй болон зарчмын бүдүүвчийг унших</p> <p>2. Хэмжилтийн хэрэгслүүдийг шапгаж тохируулах, холбоо, мэдээллийн техник хэрэгсэлд үзлэг шалгалт явуулах</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Холбоо, мэдээллийн техникийн элементүүдийн өгөгдөхүүнүүийг тодорхойлж тооцоолон бодох</p> <p>2. Техник хэрэгсэлд гарсан гэмтлийг блок, зангилгаа, хэсгээр тодорхойлж засах</p>

3. Хурдач радио телеграфчин, радиотелеграфчин, телеграфчин

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Радио, цахипгаан техникийн үндэс 2. Дунд чадлын радио станцын техникийн өгөгдөхүүн, зориулалт, ажиллагааг элемент 3. Радио станц, аппарат хэрэгсэлд хийх техник үйлчилгээний төрөл, ажлын багтаамж, үечлэл 4. Радио холбооны засвар болон жижүүрийн радионы үүрэг</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Радио станцуудын дэлгэрэнгүй бүдүүвч. элемент, зангилгаа, блокуудын ажиллагааны физикийн процесс 2. Радио саатуулгын ангилал, түүнээс хамгаалах аргууд 3. Эзэмшиж байгаа техникийн ажиллагааг шалгах дүрэм, журам, ажиллагааны үед тохиолдох гэмтэл, тэдгээрийн шалтгаан, засварлах журам, урьдчилан сэргийлэх арга</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Эзэмшиж буй станцын дэлгэрэнгүй бүдүүвч 2. Эзэмшиж буй радио станцын блокийн дэлгэрэнгүй бүдүүвч 3. Радио станцын цахилгаан тэжээлийн системийн үйл ажиллагаа 4. Дунд чадлын радиостанцыг тохируулж ажилд бэлтгэх арга</p>
---	--	--

б. Ур чадварын түвшин

<p>1. Телеграфын тэмдэгтүүдийг сонсголоор хүлээх, түлхүүрээр нэвтрүүлэх /1 минутанд хүлээн авах 70, нэвтрүүлэх 60/ 2. Радиотелеграфчид радио чигийн саадтай нөхцөлд хүлээн авсан мэдээгээ гараар буюу бичгийн машинаар бичиж сонсголын телеграфын солилцоог цагт 200 бүлгийн хурдтай хийх 3. Телеграфын аппаратаар цагт 800 бүлгийн солилцоо хийх 4. Телеграфчид үсэг хэвлэгч аппаратаар бичмэл буюу амаар хэлсэн мэдээг цагт 900 бүлгийн хурдтайгаар шуурхай солилцоо хийх 5. Холбооны цэргийн холбогдох норматив, сургуулийн үүргийг биелүүлэх 6. Радио мэдээг нэвтрүүлэх, хүлээн авах, хос солилцоо хийхэд 2-оос дээш алдаа гаргахгүй байх 7. ХНХ-д тусгай техник хэрэгслийн нормативын ашиглалтын зааврыг биелүүлэх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Станцын хэмжилтүүдийг хийж тодорхойлох 2. Телеграфын тэмдэгтүүдийг сонсголоор хүлээх, түлхүүрээр нэвтрүүлэх /1 минутанд хүлээн авах 80, нэвтрүүлэх 70/ 3. Радио чигийн саадтай нөхцөлд хүлээн авсан мэдээгээ гараар буюу бичгийн машинаар бичиж сонсголын телеграфын солилцоог цагт 240 бүлгийн хурдтай хийх 4. Телеграфын аппаратаар цагт 850 бүлгийн солилцоо хийх 5. Телеграфчид үсэг хэвлэгч аппаратаар бичмэл буюу амаар хэлсэн мэдээг цагт 1000 бүлгийн хурдтайгаар шуурхай солилцоо хийх 6. Холбооны цэргийн холбогдох норматив сургуулийн үүргийг биелүүлэх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Радиостанцын хураангуй бүдүүвчийг уншиж чаддаг байх 2. Телеграфын тэмдэгтүүдийг сонсголоор хүлээх, түлхүүрээр нэвтрүүлэх /1 минутанд хүлээн авах 90, нэвтрүүлэх 80/ 3. Радио чигийн саадтай нөхцөлд хүлээн авсан мэдээгээ гараар буюу бичгийн машинаар бичиж сонсголын телеграфын солилцоог цагт 300 бүлгийн хурдтай хийх 4. Телеграфын аппаратаар цагт 900 бүлгийн солилцоо хийх 5. Телеграфчид үсэг хэвлэгч аппаратаар бичмэл буюу амаар хэлсэн мэдээг цагт 1100 бүлгийн хурдтайгаар шуурхай солилцоо хийх 6. Холбооны цэргийн холбогдох норматив сургуулийн үүргийг биелүүлэх</p>
---	--	--

4. Шим мандлын станцын механикч

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Шим мандлын холбооны зарчим, зохион байгуулах аргууд, тэдгээрийн ололттой болон дутагдалтай талууд 2. Хариуцаж байгаа станцынхаа зориулалт, техникийн боломж, ажиллах зарчим. станцад байрласан тусгай зориулалтын багаж төхөөрөмжийн үүрэг, зориулалт хүчин чадал, байлдааны боломж 3. Хариуцаж байгаа холбооны техник хэрэгсэлд хийгдэх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Хариуцаж байгаа станцын хураангуй бүдүүвч 2. Техник үйлчилгээнд зарцуулах материалын орц, нормчлол</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Станцад тохиолдож болох гэмтлийг илрүүлэх зарчим, түүнийг засварлах, үйлчилгээ, тохируулга хийх аргууд 2. Радиорелей шим мандлын холбооны заавар</p>
---	---	--

<p>техникийн үйлчилгээний төрөл, ажлын багтаамж үечлэл</p> <p>4. Холбооны техник хэрэгсэлд мөрдөж буй заавар, журам, ашиглалтын болон техникийн баримт бичгийг хөтлөх журам</p> <p>5. Хэт өндөр үелзлийн техник хэрэгсэл дээр ажиллах үеийн аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулах арга хэмжээ</p> <p>6. Жижүүрийн механикчийн үүрэг</p> <p>7. Станцыг дэлгэн байгуулах үеийн тоотуудын үүрэг</p>		
б. Ур чадварын түвшин		
<p>1. Станцаа өдөр, шөнийн ямарч нөхцөлд ажилд бэлтгэн холбоонд орох, зангилгааны техник хэрэгсэлтэй сувгийн зохицуулалт хийж, шалгах</p> <p>2. Зэвсэгт хүчний холбооны цэргийн норматив, сургуулийн үүргийг биелүүлэх</p> <p>3. Станц, техник хэрэгсэлд хийгдэх техник үйлчилгээг бүрэн хэмжээгээр хийх</p> <p>4. Станцын иж бүрдэлд ордог хэмжилтийн багажуудыг ажиллуулж хэмжилт хийх</p> <p>5. Станцыг дэлгэн байгуулах үед аль ч тоотын үүргийг биелүүлэх</p> <p>6. Станцад холбооны аюулгүй байдлыг хангах бүх талын арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Тушаал зургийн дагуу газрын зургаар станцыг дэлгэх газар орныг олж чаддаг байх</p> <p>2. Станцыг дэлгэх ажлыг удирдах</p> <p>3. Шинээр ирсэн механикчдад сургуулийн үүрэг, нормативыг зааж сургах</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Станцад тохиолдож болох хялбар гэмтлийг илрүүлж засварлаж чаддаг байх</p>
5. Олон, цөөн сувгийн радиорелейний станцын механикч		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Радиорелейний холбооны зарчим, зохион байгуулах аргууд, тэдгээрийн ололттой болон дутагдалтай тал</p> <p>2. Хариуцаж буй станцын зориулалт, техникийн боломж, ажиллах зарчим, станцад байрласан тусгай зориулалтын багаж төхөөрөмжийн үүрэг зориулалт, хүчин чадал, байлдааны боломж</p> <p>3. Хариуцаж байгаа холбооны техник хэрэгсэлд хийгдэх техникийн үйлчилгээний төрөл, ажлын багтаамж, үечлэл</p> <p>4. Холбооны техник хэрэгслийн ашиглалтын заавар, журам, ашиглалтын болон техникийн баримт бичгийг хөтлөх журам</p> <p>5. Радиорелейний холбооны аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулах арга хэмжээ</p> <p>6. Жижүүрийн радиорелейний механикчийн үүрэг</p> <p>7. Станцыг дэлгэх үеийн тоотуудын үүрэг</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Хариуцаж буй станцын хураангуй бүдүүвч</p> <p>2. Техник үйлчилгээнд зарцуулах материалын орц, нормчлол</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Станцад тохиолдож болох хялбар гэмтлийг илрүүлэх зарчим, түүнийг засварлах, үйлчилгээ тохируулга хийх аргууд</p> <p>2. Радиорелей, шим мандлын холбооны заавар</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Станцаа өдөр шөнийн ямарч нөхцөлд ажилд бэлтгэн холбоонд орж, зангилгааны техник хэрэгсэлтэй сувгийн зохицуулалт хийж, шалгаж чаддаг байх</p> <p>2. Зэвсэгт хүчний холбооны цэргийн норм зт/в сургуулийн</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Станцыг дэлгэн байгуулахад удирдаж чаддаг байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Станцад тохиолдож болох хялбар гэмтлийг илрүүлж засварлаж чаддаг байх</p>

<p>үүргийг биелүүлж чаддаг байх</p> <p>3. Станц, техник хэрэгсэлд хийгдэх техник үйлчилгээг бүрэн хэмжээгээр хийж чаддаг байх</p> <p>4. Станцын иж бүрдэлд ордог хэмжилтийн багажуудыг ажиллуулж хэмжилт хийж чаддаг</p> <p>5. Станцыг дэлгэн байгуулах үед аль ч тоотын үүргийг биелүүлж чаддаг байх</p> <p>6. Станцад холбооны аюулгүй байдлыг хангах бүх таль н арга хэмжээг хэрэгжүүлж чаддаг байх</p>	<p>2. Тушаал зургийн дагуу газрын зургаар станцыг дэлгэн байгуулах газар орныг олж чаддаг байх</p>	
--	--	--

6. Цахилгаан тэжээлийн станцын механикч

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Цахилгаан тэжээлийн станцын зориулалт, техникийн боломж, ажиллах зарчим, эд ангиудын зориулалт, станцад байрласан тусгай зориулалтын багаж төхөөрөмжийн үүрэг зориулалт, хүчин чадал, байлдааны боломж</p> <p>2. Цахилгаан тэжээлийг станцад хийгдэх техник үйлчилгээний төрөл, ажлын багтаамж үечлэл</p> <p>3. Цахилгаан станц дээр ажиллах үеийн аюулгүй байдлыг хангах талаар зохион байгуулах арга хэмжээ</p> <p>4. Цахилгаан тэжээлийн станцын жижүүрийн механикчийн үүрэг,</p> <p>5. Станцын газардуулгыг хийх зарчим, хэмжих аргачлал</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Цахилгаан тэжээлийн станцын хянах салбарын ашиглах зарчмыг хураангуй бүдүүвч</p> <p>2. Техник үйлчилгээнд зарцуулах материалын орц, нормчлол</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Цахилгаан тэжээлийн станцад тохиолдож болох хялбар гэмтлийг илрүүлэх зарчим, түүнийг засварлах, үйлчилгээ, тохируулга хийх аргууд</p>
--	--	--

б. Ур чадварын түвшин

<p>1. Зэвсэгт хучний холбооны цэргийн норматив, сургуулийн үүргийг биелүүлж чаддаг байх</p> <p>2. Цахилгаан тэжээлийн станцад хийгдэх техник үйлчилгээг бүрэн хэмжээгээр хийж чаддаг байх</p> <p>3. Станцад холбооны аюулгүй байдлыг хангах бүх талын арга хэмжээг хэрэгжүүлж чаддаг байх</p> <p>4. Станцын иж бүрдэлд ордог хэмжилтийн багажуудыг ажиллуулж чаддаг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Цахилгаан тэжээлийн хураагууруудыг цэнэглэж чаддаг байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Цахилгаан тэжээлийн станцад тохиолдож болох хялбар гэмтлийг илрүүлж, засварлаж чаддаг байх</p>
--	---	---

7. Олон хосын болон өндөр үелзлийн кабелийн мэргэжилтнүүд

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Утсан холбоог зохион байгуулах зарчим, аргууд тэдгээрийн ололттой болон дутагдалтай талуудыг мэддэг</p> <p>2. Олон хосын /өндөр үелзлийн/ кабелийн тактик техникийн өгөгдөхүүн, байлдааны боломжийг мэддэг</p> <p>3. Олон хосын /өндөр үелзлийн/ кабельд хийгдэх техник үйлчилгээг мэддэг байх</p> <p>4. Кабелийн гэмтэл олох багажийг ажигд бэлтгэх дараалал, хэмжилт хийх зарчмыг мэддэг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Кабелийн гэмтэл олох багажийг ашиглаж мэддэг байх.</p> <p>2. Кабелийн үйлчилгээнд зарцуулах материалын орц, нормчлолыг мэддэг байх.</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Кабелийн гэмтлийг тодорхойлж кабелийг залгах бүх аргыг мэддэг байх</p>
---	---	---

5. Кабелийн шугамын магадлууруудыг хэмжих, ашиглалтад тэнцэх эсэхийг мэддэг байх		
5. Ур чадварын түвшин		
<p>1. Зэвсэгт хучний холбооны цэргийн норматив, сургуулийн үүргийг биелүүлж чаддаг байх</p> <p>2. Кабельд техник үйлчилгээ хийж чаддаг байх</p> <p>3. Хэмжигч багажаар кабелийн шугам дахь гэмтлийн шинж тэмдэг, гэмтэл хуртэлх зайг тодорхойлж чаддаг</p> <p>4. Кабелийн шугамын магадлууруудыг хэмжих, тэдгээр нь ашиглалтад тэнцэх эсэхийг тодорхойлж чаддаг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Кабель шугамын тусгаарлагчийн эсэргүүцэл, тогтмол гүйдэлд үзүүлэх эсэргүүцэл хэмжиж чаддаг байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Кабелийн гэмтлийг хэмжигч багажаар тодорхойлж, кабелийг залгах бүх терлийн аргыг хийж чаддаг байх</p>
8. Олон сувгийн нягтруулгын хэрэгслийн механикч		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Техник хэрэгслийн зориулалт, техникийн уйлчилгээний төрөл, ажлын багтаамж, үечлэлийг мэддэг байх</p> <p>2. Техник хэрэгсэлд хийгдэх техникийн ажлын багтаамж, үечлэлийг мэддэг байх</p> <p>3. Олон сувгийн нягтруулгын хэрэгслийн механикчийн үүргийг мэддэг байх</p> <p>4. Олон сувгийн нягтруулгын техникт сувгийн нийцүүлэлт хийх зарчмыг мэддэг байх</p> <p>5. Холбооны техник хэрэгсэлд ашиглалтын талаар мөрдөж буй заавар, журам. ашиглалтын болон техникийн баримт бичгийг хөтлөх журмыг мэддэг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Нягтруулгын хэрэгслийн ажиллагааг хураангуй бүдүүвчээр тайлбарлаж чаддаг байх</p> <p>2. Нягтруулгын хэрэгслийн хоорондох кабелийн шугамыг хэмжиж мэддэг байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Нягтруулгын хэрэгсэлд тохиолдож болох хялбар гэмтлийг илрүүлэх зарчим, түүнийг засварлах, үйлчилгээ тохируулга хийх аргуудыг мэддэг байх</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Зэвсэгт хучний холбооны цэргийн норматив, сургуулийн үүргийг биелүүлж чаддаг байх</p> <p>2. Нягтруулгын техник хэрэгсэлд техник үйлчилгээг бүрэн хэмжээгээр хийж чаддаг байх</p> <p>3. Холбооны техник хэрэгслээ ямарч нөхцөлд ажилд бэлэн байлгаж, зангилгааны техник хэрэгсэлтэй сувгийн нийцүүлэлт хийж, шалгаж чаддаг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1 Хэмжилтийн багажуудыг ашиглан суваг, шугамыг хэмжиж үнэлэлт өгч чаддаг байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Нягтруулгын хэрэгсэлд тохиолдож болох хялбар гэмтлийг илрүүлэн засварлаж чаддаг байх</p>
9. Холбоо, мэдээлэл техник хэрэгслийн засварчин		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Радио техник, цахилгаан техникийн онолын үндсийг мэддэг байх</p> <p>2. Радиоэлектроникийн функциональ бүдүүвч дэх тэмдэглэгээнүүд</p> <p>3. Радиоэлектроны деталиудын ерөнхий үүрэг, тэмдэгпэгээ, номиналь хэмжээ</p> <p>4. Завсарын үеийн аюулгүй ажиллагааны дүрмийг мэдэж биелүүлдэг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Зарчмын бүдүүвчийг уншиж тайлах</p> <p>2. Холбооны хэрэгслийн гэмтлийг эрж олох аргуудыг мэддэг байх</p> <p>3. Холбооны хэрэгслийн зохион байгуулалт, дэлгэрэнгүй бүдүүвч, физикийн процессийг мэддэг байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1.Төрөл бүрийн хэмжмх хэрэгслийг ашиглан холбооны хэрэгслийн параметруудийг шалгаж тохируулах аргыг мэддэг байх</p> <p>2.Төрөл бүрийн хэмжих хэрэгсэл ашиглах журам, зориулалтыг мэддэг байх</p>

5.Төрөл бүрийн хэмжих хэрэгслийн ажиллагаа, зориулалт, ашиглах журмыг мэддэг байх	4. Холбооны хэрэгслүүдийн ашиглалтын заавар, урьдчипан сэргийлэх арга хэмжээ, хэвшүүлэх ажлын агуулгыг мэддэг байх	3. Холбооны хэрэгслийн гэмтлийг эрж олох аргуудыг мэддэг байх
б. Ур чадварын түвшин		
1. Хэмжих багаж ашиглан радио электроны деталиудын үндсэн магадлуурдуудыг хэмжих 2. Техник хэрэгсэлд гарсан гэмтлийг блок, зангилгаа хэсгээр тодорхойлж арилгах 3. Засвар хийсэн холбооны хэрэгсэлд төрөл бүрийн тохируулга хийх 4. Мэргэжлийн бэлтгэлийн холбогдох нэг бүрийн норматив, сургуулийн үүргийг биелүүлэх	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Хэмжих багаж ашиглан блок, эд ангиудын магадлуурдуудыг хэмжих 2. Техник хэрэгсэлд гарсан гэмтлийг шаталсан блок, зангилгаагаар тодорхойлж засах 3. Холбооны хэрэгслийн дэлгэрэнгүй бүдүүвч, зургийг уншиж чаддаг байхаас гадна, засварын ажилд ашиглаж сурсан байх	II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Зарчмын бүдүүвч ашиглан холболтын бүдүүвч зохион угсрах 2. Техник хэрэгсэлд гарсан гэмтлийг детальчлан тодорхойлж засах 3. Холбооны хэрэгслийн монтажийн өөрчлөлт оруулахгүйгээр засварыг чанар сайтай хийх
10. Шууданчин		
а. Мэдлэгийн түвшин		
1. Зарлага, шуудан холбооны үүрэг зорилго, онцлог 2. Шуудан холбооны заавар журам 3. Холбооны аюулгүй байдлыг хангах дүрэм, заавар 4. Цэргийн анги, байгууллагуудын албаны болон захидал харилцааны дугаар	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Цэргийн анги, байгууллагуудын байрласан газар, очих зам 2. Албан бичиг, баталгаатай болон ил захидлыг хаяглах, олгох, хүлээн авах журмыг мэддэг байх	II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Нууцын хадгалалт, хамгаалалттай холбоотой хууль эрх зүйн үндэс
б. Ур чадварын түвшин		
1. Албан бичиг, баталгаатай болон ердийн захидлуудыг хяналтын /24 цагийн/ хугацаанд багтааж хаягт эзэнд нь хүргэх 2. Албан бичиг, захидлыг ээлжийнхээ 1 цагийн хугацаанд 50-70 нүдэнд ялган хийх	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Албан бичгийн захидлуудыг хаягаар нь алдаагүй ялгаж, тус бүр 200-300 ширхэг бүхий 20 боодлыг 3 цагийн дотор боох 2.1000 доошгүй албан бичиг, захидлыг ээлжинхээ 1 цагийн хугацаанд 70-100 нүдэнд ялгах	
11. Программчин		
а. Мэдлэгийн түвшин		
1.Мэдээллийн техник хэрэгслийн онолын үндсийг мэддэг байх 2.Тооцоолох электрон машины хүчин чадал, зориулалт, ажиллагааны зарчмыг мэддэг байх 3.Микро бүдүүвчийн үндсэн элементүүдийн үүрэг зориулалт, тэмдэглэгээ, номиналь хэмжээг мэддэг байх 4.Мэдээллийн техникийн аюулгүй ажиллагааны дүрмийг мэдэж биелүүлдэг байх	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1.Программчлалын 4-өөс доошгүй хэл мэддэг байх 2.Тооцоолох электрон машины гэмтлийг эрж олон аргуудыг мэддэг байх 3.Бодлогын даалгаврыг боловсруулах аргачлал	II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Цэргийн хэрэгт программчлалын гүйцэтгэх үүрэг, үндэс, чиг хандлага 2. Мэдээллийн дайн, кибер халдлагын үндэс, түүнтэй тэмцэх арга зам

	4.Бүх төрлийн хэрэглээний программуудын үндсийг мэддэг байх	
2. Ур чадварын түвшин		
1.Бодлогын даалгаврын программыг технологийн шаардлагын дагуу бичих	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1.Программ хангамжинд өөрчлөлт хийх алдааг засах 2. Бодлогын даалгаврыг боловсруулах	II зэрэгт тавигдах шаардлагыг бүрэн хангасан байна.
13. Цэргийн мэдээллийн мэргэжилтэн		
а. Мэдлэгийн түвшин		
1. Мэдээллийн техник хэрэгслийн онолын үндсийг мэддэг байх 2. Мэдээлэл боловсруулах орчин үеийн арга, технологи 3. Мэдээллийн техникийн болон мэдээллийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ 4. Тооцоолох электрон машины тухай онолын мэдлэгтэй байх 5. Мэдээллийн сангийн тухай ойлголт	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1.Сүлжээний ойлголт 2.Программ хангамжинд өөрчлөлт хийх, алдааг засах мэдлэгтэй байх 3.Гадаад орнуудын армийн нэгтгэл, ангиудад ашиглагдаж байгаа мэдээллийн техник хэрэглсийн үндсийг судлаж мэдэх	II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1.Сүлжээний онол 2.Программчлалын тухай анхан шатны мэдлэгтэй байх 3.Байлдааны болон тайван цагт цэргийн удирдлагын холбоотой мэдээлэл цуглуулах, боловсруулах, дамжуулах, хадгалах
2. Ур чадварын түвшин		
1. Хэрэглээний 3-аас доошгүй программыг бүрэн ажиллуулах 2. Мэдээллийн сангийн төрөл бүрийн программуудтай ажиллах 3. Хэрэглээний программ дээр ажиллах	III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1. Хэрэглээний 4-өөс доошгүй программыг бүрэн ажиллуулах 2. Системийн болон программ хангамжийн гэмтлийг илрүүлэх чадвартай байх 3. Сүлжээнд ажиллах 4. Программ хангамжийн гэмтлийг илрүүлэх	II зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна: 1.Хэрэглээний 5-аас доошгүй программыг бүрэн ажиллуулах 2. Мэдээллийн сангийн бүтэц, загварыг тодорхойлох 3. Дотоод болон гадаад сүлжээнд ажиллах байгууллага, хувь хүмүүсийн мэдээллийн сантай ажиллах 4. Мэдээллийн сантай ажиллах

Дөрөв. Химийн цэргийн мэргэжлээр

III зэрэг	II зэрэг	I зэрэг
1. Химийн стратеги-тактик, командын офицер		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Ерөнхий тактикийн үндэс (ерөнхий цэргийн нэгдэл, нэгтгэлийн түвшинд) 2. ҮОХЗ, түүний шинэ төрлүүд, тэдгээрийн хөнөөх хүчин зүйлүүд 3. ҮОХЗХ ба байлдааны хими, хими-техникийн хангалтын арга хэмжээнүүд 4. Химийн цэргийн бүтэц, зохион байгуулалт, боломж 5. Химийн цэргийн зэвсэглэл ба хамгаалах хэрэгсэлийн зориулалт, боломж, байлдаанд ашиглах 6. Утаат болон шатаах хэрэгслийн төрөл, найрлага, байлдаанд хэрэглэх үндэс 7. Гадаадын цэргийн хими-хамгаалалтын анги салбаруудын зохион байгуулалт, зэвсэглэл</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчин, цэргийн бүлэглэлийн хэмжээнд ҮОХЗ ба байлдааны хими-хими техникийн хангалтын төлөвлөлт, зохион байгуулалт 2. Хими, радиац, биологи, хүчтэй үйлчилгээтэй хордуулах бодис /ХҮХБ/-уудын цагийн байдал үнэлэх аргачлал 3. Утаат хэрэгсэл ашиглах тооцоо, шатаах хэрэгслээс хамгаалах арга 4. Цэвэрлэгээний район дэлгэж тусгай цэвэрлэгээ хийх арга 5. Химийн цэргийн зэвсэглэл ба хамгаалах хэрэгслийг ашиглах, хадгалах, арчилж хамгаалах, ССТҮ хийх технологи 6. Хүн малын гоц халдварт өвчний хор уршгийг арилгах арга зам</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Хими хамгаалалтын батальоныг байлдаанд ашиглах үндэслэл 2. Зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэх үеийн ҮОХЗ ба байлдааны хими-хими техникийн хангалтыг зохион байгуулах үндэс 3. Цэрэг, зэвсгийн өнгөлөн далдлалтад утаат хэрэгсэл, хөөсөнцөр, хивсэнцэр ашиглах, шатаах хэрэгсэл хэрэглэх 4. Атомын цахилгаан станц болон ХҮХБ ашигладаг үйлдвэрт гарсан томоохон ослын үед үүсэх хор уршгийг арилгах арга технологи</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. ҮОХЗХБ, Химийн тусгай бэлтгэлийн нормативууд 2. Хими, радиац, биологийн цагийн байдал үнэлэх 3. Ерөнхий цэргийн нэгдэл, нэгтгэлийн ҮОХЗХ ба байлдааны хими, хими-техникийн хангалтын арга хэмжээнүүдыг авч хэрэгжүүлэх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчин, цэргийн бүлэглэлийн хэмжээнд ҮОХЗ ба байлдааны хими-хими техникийн хангалтыг зохион байгуулах Химийн хангалтын байлдааны баримт бичиг боловсруулах 2. Химийн тусгай тоноглолтой техник, багаж хэрэгсэл дээр ажиллах</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагуудыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэх үеийн ҮОХЗ ба байлдааны хими-хими техникийн хангалтыг төлөвлөж, зохион байгуулах 2. Цэрэг, зэвсгийг өнгөлөн далдлах</p>
2. Химийн командын офицер		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Ерөнхий тактикийн үндэс (ерөнхий цэргийн анги, салбарын түвшинд) 2. ҮОХЗ, түүний төрлүүд, тэдгээрийн хөнөөх хүчин зүйлүүд, хамгаалах арга</p>	<p>3 дугаар зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Хими, радиац, биологийн цагийн байдал</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Ерөнхий цэргийн болон төрөл тусгай</p>

<p>3.ҮОХЗХ ба хими, хими-техникийн хангалтын үндсэн арга хэмжээнүүд</p> <p>4.Химийн анги, салбарын бүтэц, зохион байгуулалт, боломж, байлдаанд ашиглах үндэслэл</p> <p>5.Тусгай цэвэрлэгээний бодис, уусмалын зориулалт, найрлага, тооцоо</p> <p>6.Утаат болон шатаах хэрэгслийн төрөл, зориулалт, найрлага, байлдаанд ашиглах</p> <p>7.Гадаадын цэргийн химийн анги салбарын зохион байгуулалт, зэвсэглэл</p> <p>8.Химийн техник, тусгай тоноглол, бодис уусмалтай ажиллах үеийн аюулгүйн арга хэмжээ</p>	<p>үнэлэх</p> <p>2.Хими хамгаалалтын салаа, салбарыг байлдаанд ашиглах үндэслэл</p> <p>3.Цэвэрлэгээний район дэлгэж тусгай цэвэрлэгээ хийхэд салбарыг удирдах</p> <p>4.Утаат халхлалтыг төлөвлөх тооцоолох, шатаах хэрэгслээс хамгаалах</p> <p>5.Химийн цэргийн зэвсэглэл, хамгаалах хэрэгслийг хадгалах, арчилж хамгаалах, засвар үйлчилгээ хийх</p> <p>6.ХҮХБ-ын төрөл, шинж чанар, хор уршиг, хамгаалах арга</p> <p>7.Хүн малын гоц халдварт өвчний хор уршгийг арилгах</p>	<p>мэргэжлийн анги, салбарын ҮОХЗ ба байлдааны хими-хими техникийн хангалтыг зохион байгуулах үндэс</p> <p>2.Хими хамгаалалтын тусгай ротыг байлдаанд ашиглах үндэслэл</p> <p>3.Өнгөлөн далдлалтад утаат хэрэгсэл, хөөсөнцөр, хивсэнцэр ашиглах</p> <p>5.Байлдааны баримт, бичгүүдийн боловсруулалт</p> <p>6.Хүчтэй үйлчилгээтэй хордуулах бодисуудын шинж чанар, болзошгүй аюулын цагийн байдлыг үнэлэх</p>
--	--	--

б. Ур чадварын түвшин

<p>1. ҮОХЗХБ, Химийн тусгай бэлтгэлийн нормативуудыг биелүүлэх</p> <p>2.Химийн тусгай тоноглолтой техник, багаж хэрэгсэл дээр ажиллах</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1.Хими, радиац, биолог, ХҮХБ-ын цагийн байдал үнэлэх</p> <p>3.Хими хамгаалалтын салаа, салбарын ажиллагааг зохион байгуулж, удирдах</p>	<p>II зрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Мэргэжлийн салаа, салбарыг байлдаанд удирдах</p> <p>4.Зэвсэг, байлдааны техникт тусгай цэвэрлэгээ хийх, түүнийг зохион байгуулах, удирдах</p>
---	---	--

3. Химийн техникийн офицер (тооцоо-шинжилгээний)

а. Мэдлэгийн түвшин

<p>1.ҮОХЗ, түүний шинэ төрлүүд, тэдгээрийн хөнөөх хүчин зүйлүүд, хамгаалах арга</p> <p>2.Хими, радиац, биологийн цагийн байдлыг үнэлэх, ажлын зурагт оруулах</p> <p>3.ХҮХБ-ын шинж чанар, болзошгүй аюулын цагийн байдлыг үнэлэх</p> <p>4.Цацраг идэвхт болон байлдааны хорт бодис, цэвэрлэгээний бодис уусмал, утаат хэрэгслээс дээж сорил авах, лабораторын шинжилгээ хийх, дүгнэлт гаргах</p> <p>5.Агуулахад хадгалалтад байгаа ХЦЗ ба ХХ-д лабораторын шинжилгээ хийж зэрэг тогтоох</p> <p>6.Байлдааны хорт бодис, ХҮХБ-ын ангилал, хоруу шинж чанар, далайц, хор уршиг</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1.ТШС, тооцоолон шинжлэх бүлгийг байлдаанд ашиглах үндэслэл</p> <p>2.Химийн лабораторыг байлдаанд ашиглах үндэслэл</p> <p>3.Цөмийн дэлбэрэлт, химийн дайралт, биологийн хэрэгсэл, цаг агаарын мэдээлэл олдворлох, боловсруулах</p> <p>4.Хими, радиац, биологийн цагийн байдлыг урьдчилсан болон тагнуулын аргаар үнэлэх, тооцоог хийх, үнэлэх, ашигтай хувилбар боловсруулах, илтгэх</p> <p>5.Хүн малын гоц халдварт өвчний хор уршгийг арилгах тооцоо, лабораторын шинжилгээ</p> <p>6.Атомын цахилгаан станц болон ХҮХБ</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1.Цөм, хими, биологийн зэвсгийг байлдаанд хэрэглэх үндэслэл</p> <p>2.Үндсэн төрлийн байлдаанд ТШС, ХЛ-ыг ашиглах үндэслэл, хөгжлийн чиг хандлага</p> <p>3.Тусгай хяналтын батальон /обск/-ыг байлдаанд ашиглах үндэслэл</p> <p>4.Тооцоолон шинжлэх станц, тооцоолон шинжлэх бүлгийн үйл ажиллагааг удирдах, ахлах даргыг мэдээллээр хангах</p> <p>5.Химийн лабораторын үйл ажиллагааг удирдах, ахлах даргыг мэдээллээр хангах</p> <p>6.Байлдааны баримт, бичгүүдийг боловсруулах</p>
---	--	---

	ашигладаг үйлдвэрт гарсан томоохон ослын үед үүсэх хор уршгийг арилгах тооцоо	
б. Ур чадварын түвшин		
1.ҮОХЗХБ, Химийн тусгай бэлтгэлийн норматив 2.Химийн урвалжуудыг бэлтгэх	III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна: 1.Хорт бодис бүхий сорьцонд тоон ба чанарын анализ хийх 2.ПХЛ-54, ДП-100 ашиглан лабораторын шинжилгээ хийх	II зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна: 1.РАСТ-1 м машиныг ашиглан тооцоо боловсруулах 2.АЛ-4 машиныг ашиглан лабораторын шинжилгээ хийх
4. Химийн техникийн офицер (засвар үйлчилгээний)		
а. Мэдлэгийн түвшин түвшин		
<p>1. Ерөнхий цэргийн байлдааны үндэс</p> <p>2. Бүх төрлийн байлдааны материал хэрэгслийн төлөвлөлт, хангалт</p> <p>3. Цэргийн ар талын зохион байгуулалт</p> <p>4. Цэргийн хөдөлгөөн</p> <p>5. Тээвэрлэлт, татан гаргалт</p> <p>6. Техникийн төлөвлөлт хангалт, засвар, үйлчилгээ</p> <p>7. Хүн эмнэлгийн төлөвлөлт, хангалт, эмчилгээ, үйлчилгээ</p> <p>8. Цэргийн ар талын удирдлага</p> <p>9. ПАЗ-ийн төлөвлөлт хангалт</p> <p>10. Материал хэрэгслийн нөөц, цувраажилтийн норм</p> <p>11. Бүх төрлийн үйлчилгээ, худалдааны ойлголт</p> <p>12. Нас барагсад түүнд үзүүлэх хүндэтгэл</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангахаас гадна</p> <p>1. Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндэс</p> <p>2. Ар тал, техникийн анги, салбар, бүлгийн зохион байгуулалт, үүрэг, тэдгээрийг ашиглах үндэс</p> <p>3. Анги, салбарыг сэргээн босгох үеийн ар тал, техникийн хангалтын үндсэн арга хэмжээ</p> <p>4. Ерөнхий нэгтгэл, анги, цэргийн бүлэглэлийн ар тал, техникийн хангалт, удирдлага, төлөвлөлт</p> <p>5. Энхийг дэмжих ажиллагааны ар талын хангалтын зарчим</p> <p>6. Цэргийн олзлогсодын хангалтын асуудлууд</p> <p>7. Дүрэвэгсдийн хангалтын асуудлууд</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчний дэлгэн байгуулалт, шилжүүлэн бүлэглэлтийн үе дэх ар тал, техникийн хангалтын үндсэн арга хэмжээнүүд, тэдгээрийн төлөвлөлтийн үндэс</p> <p>2. Улсын дайчилгаа, улсын эдийн засгийн хүчин чадавхийг цэргийн зориулалтаар ашиглах боломж</p> <p>3. Ерөнхий цэргийн нэгтгэл, анги, цэргийн бүлэглэлийн ар тал, техникийн хангалтын удирдлага</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндсэн зарчимд тулгуурлан ар талын анги, салбарыг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах ажлыг удирдах чадвартай байх</p> <p>2. Зэвсэгт хүчний ар талын анги салбаруудтай явуулах КШХС-ийн бодлого, тактик тусгай бэлтгэлийн хичээлийн төлөвлөлт боловсруулж чаддаг, удирдаж явуулах дадлага эзэмшсэн байх</p> <p>3. Ар талын анги салбарын орон тоо, зохион байгуулалт, шаардагдах техник табель хэрэгслийг анги салбарын гүйцэтгэх үүрэгт нь зохицуулан тооцож чаддаг байх</p> <p>4. Тайван ба байлдааны цагт материал хэрэгслийн хангалтыг удирдан зохион байгуулах ур чадвар эзэмшсэн байх</p> <p>5. Ар талын техник, тоног төхөөрөмжийн улирлын болон сэргээн сайжруулах үйлчилгээ засвар хийж чаддаг байх</p> <p>6. Ар талын бүх төрлийн нормативуудыг биелүүлж чаддаг</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Ар талын хангалтыг бүх төрлийн тооцоог хийж, бичиг баримтыг боловсруулах</p> <p>2. Алсын болон ойрын зайд цэрэг, материал хэрэгслийн газар, агаар, усан замын тээвэрлэлтийг төлөвлөн зохион байгуулах</p> <p>3. Нэгтгэл, анги, салбарыг сэргээн босгох үеийн ар тал, техникийн хангалтыг төлөвлөх</p>	<p>II, III зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчний дэлгэн байгуулалт, шилжүүлэн бүлэглэлтийн үе дэх ар тал, техникийн хангалтын төлөвлөлтийг хийх, зохион байгуулах</p> <p>2. Нэгтгэл, анги, салбарыг сэргээн босгох үеийн ар тал, техникийн хангалтыг зохион байгуулах</p>

байх		
2. Командын /Ар талын төрөл мэргэжлээр/		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1.Ерөнхий цэргийн байлдааны үндэс, үндсэн төрлийн байлдаанд анги, салбаруудыг ашиглах зарчмыг өөрийн албан тушаалаас нэг шат дээгүүр албан тушаалд чадварлаг ашиглах онолын мэдлэг эзэмшсэн байх</p> <p>2.Бүх төрлийн байлдааны ар талын хангалтын онцлог</p> <p>3.Цэргийн ар талын зохион байгуулалт</p> <p>4.Материал хэрэгслийн төлөвлөлт</p> <p>5.Тээвэрлэлт ба татан гаргалт</p> <p>6.Цэргийн хөдөлгөөн</p> <p>7.Техникийн төлөвлөлт хангалт</p> <p>8.Мал эмнэлэгийн төлөвлөлт хангалт</p> <p>9.Хүн эмнэлэгийн төлөвлөлт хангалт</p> <p>10.Төрөл бүрийн байлдааны ар талын хангалт</p> <p>11.Төрөл бүрийн байлдааны техникийн хангалт</p> <p>12.Төрөл бүрийн байлдааны ПАЗ-ийн хангалт</p> <p>13.Байлдааны ажиллагааны үе дэх албаны даргын үүрэг ажлын дараалал</p> <p>14.Нөөцийн материал хэрэглэлийн нөхцөл, хугацаа, сольж шинэчлэх, бүртгэж тооцох</p> <p>15.Материал хэрэглэлийн хорогдлыг тооцох норм, аргачлал</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Энхийг сахиулах хүчний ар талын хангалтын зарчим</p> <p>2. Материал хэрэгслийн нөөцийн ангилал, зориулалт, цувраажилтын норм</p> <p>3. Тайван ба байлдааны цагт нэг хүн, нэгж техникт зарцуулагдах материал хэрэглэл</p> <p>4. Бараа бүтээгдэхүүний химийн найрлага, бүтэц шинж чанар, төрөл, ангилал, зориулалт</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндсэн зарчим</p> <p>2. Ар талын анги, салбарын зохион байгуулалт, ашиглах зарчим</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1.Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндсэн зарчмыг гүнзгий мэдэж, ар талын анги, салбарыг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах асуудлыг мэддэг</p> <p>2. Зэвсэгт хүчний ар талын анги, салбаруудтай явуулах КШХС бодлого, тактик тусгай бэлтгэлийн хичээлийн төлөвлөлт боловсруулж чаддаг, удирдаж явуулах дадлага эзэмшсэн байх</p> <p>3. Ар талын анги, салбарын орон тоо зохион байгуулалт, шаардагдах техник табель хэрэгслийг анги, салбарын гүйцэтгэх үүрэг нь зохицуулан тооцож чаддаг</p> <p>4. Тайван ба байлдааны цагт материал хэрэгслийн хангалтыг удирдан зохион байгуулах ур чадвар эзэмшсэн байх</p> <p>5. Ар талын техник, тоног төхөөрөмжийн улирлын болон сэргээн сайжруулах үйлчилгээ, засвар хийж чаддаг байх</p> <p>6. Ар талын бүх төрлийн нормативуудыг биелүүлж чаддаг байх</p> <p>7. Нэгтгэл, анги, салбаруудын КШХС-д ар талын зүгээс хийгдэх төлөвлөлт, баримт бичгийг боловсруулж чаддаг байх</p> <p>8. Тайван ба байлдааны цагийн материал хэрэглэлийн</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1.Ар талын хангалтын бүх төрлийн тооцоо хийж чаддаг дадлагатай</p> <p>2. Тайван ба байлдааны цагт нэг нэгж техникт зарцуулагдах материал хэрэгслийн тооцоог бодож тооцоолж чаддаг байх</p> <p>3. Материал хэрэгслийн нөөцийг цувраажилтын нормын дагуу тоцоолж, хангалтыг зохион байгуулах чадвартай байх</p> <p>4.Материал хэрэгслийн хорогдлыг нормын дагуу тооцох чадвартай байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1.Ар талын хангалтын тооцоог хэд хэдэн хувилбараар хийдэг дадлага эзэмшсэн байх</p> <p>2. Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийг боловсруулж чаддаг байх</p> <p>3. Ар талын анги, салбарыг удирдан зохион байгуулах чадвартай байх</p>

<p>хангалтын тооцоог хийж чаддаг байх</p> <p>9. Ар талын бие бүрэлдэхүүнд заагдах тусгай бэлтгэлийн хчизэлийг удирдан явуулах чадвар эзэмшсэн байх</p> <p>10. Материал хэрэглэлийн чанар байдлыг тодорхойлох чадвартай байх</p>		
3. Инженер-техникийн мэргэжилтэн /офицер/		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Ар талын техник, тоног төхөөрөмжийн марк, төрөл зориулалт</p> <p>2. Ар талын техник табель хэрэгслийн хүчин чадал, боломж</p> <p>3. Ар талын техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Ар талын техник, тоног төхөөрөмжинд гарах гэмтлүүд, түүнийг засах арга зам</p> <p>2. Материал хэрэглэлийн чанар, байдлыг шалгах лабораторуудын төрөл тэдгээрийн зориулалт</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Ар талын анги, салбаруудын тоног төхөөрөмжийг ажиллуулах зарчим</p> <p>2. Шатахуун хадгалах агуулахын бүтэц зохион байгуулалт</p> <p>3. Аммиакан хөргүүртэй зоорины бүтэц зохион байгуулалт</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Ар талын техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах зарчмыг мэддэг, ажиллуулж чаддаг байх</p> <p>2. Ар талын материал хэрэглэл, техник, тоног төхөөрөмжинд урсгал болон бага, дунд засварыг хийж чаддаг байх</p> <p>3. Ар талын бие бүрэлдэхүүнд мэргэжлийнхээ 3 чиглэлээр сургалт явуулах чадвартай байх</p> <p>4. Тайван ба байлдааны цагт техник хэрэгсэлд зарцуулагдах материал хэрэглэлийн тооцоог бодож, тооцоолж чаддаг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Ар талын техник, тоног төхөөрөмжинд гарах гэмтлүүдийг илрүүлж, засаж чаддаг байх</p> <p>2. Ар талын табель хэрэгслийг цувраажилтын нормын дагуу тооцоолж, хангалтыг зохион байгуулах чадвартай байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Ар талын анги, салбаруудын тоног төхөөрөмжүүдийг дэлгэн ажиллуулах чадвартай байх</p> <p>2. Шатахуун хадгалах агуулахын тоног төхөөрөмжүүдийг ажиллуулан, шатахуун тавьж олгох чадвартай байх</p> <p>3. Аммиакан хөргүүртэй зоорины ажлын зарчмыг мэддэг засвар үйлчилгээг зохион байгуулах чадвартай байх</p>
4. Инженер –техникийн мэргэжилтэн /ахлагч/		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Өөрийн хариуцаж байгаа ар талын техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах зарчим</p> <p>2. Нөөцийн материал хэрэглэлийн хадгалалтын нөхцөл, хугацаа, сольж шинэчлэх, бүртгэж тооцох</p> <p>3. Ар талын материал хэрэглэл, техник, тоног төхөөрөмжинд хөтлөгдөх бичиг баримт, бүртгэл тооцоог хийх журмыг мэддэг байх</p> <p>4. Ар талын техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ</p>	<p>III зэрэгт тааигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Ар талын техник, табель хэрэгслийн тактик техникийн өгөгдөхүүн</p> <p>2. Материал хэрэглэлийн ангилал, марк, зориулалтыг мэддэг байх</p> <p>3. Ар талын техник, тоног төхөөрөмжинд гарах гэмтлүүд, түүнийг засах арга зам</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Ар талын бүх төрлийн техник, тоног төхөөрөмжүүдийг ажиллуулах журам, засвар үйлчилгээ, хадгалалт, хамгаалалтын заавар</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Өөрийн хариуцаж байгаа ар талын техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах чадвартай</p> <p>2. Нөөцийн материал хэрэглэлийн хадгалалтын нөхцөл,</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Материал хэрэглэлийн ангилал, марк.</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Ар талын бүх төрлийн техник, тоног</p>

<p>хугацаа, сольж шинэчлэх, бүртгэл тооцоог хөтөлж чаддаг байх</p> <p>3. Ар талын техник, тоног төхөөрөмжинд хөтлөгдөх бичиг баримт, бүртгэл тооцоог хийж чаддаг</p> <p>4. Ар талын техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж чаддаг байх</p> <p>5. Бүтээгдэхүүнээс дээж авч түүний шинж чанарыг тодорхойлж чаддаг байх</p>	<p>зориулалтыг тодорхойлж чадах чадвартай байх</p> <p>2. Ар талын техник, тоног төхөөрөмжинд гарах гэмтлүүдийг илрүүлж, засаж чаддаг байх</p>	<p>төхөөрөмжүүдийг ажиллуулах зарчмыг мэддэг, ажиллуулж чаддаг байх</p>
---	---	---

5. Пуужин, артиллерийн зэвсэглэлийн мэргэжлээр (офицер)

а. Мэдлэгийн түвшин

<p>1.Ерөнхий цэргийн байлдаан үндэс</p> <p>2. Ар талын хангалтын зохион байгуулалт</p> <p>3. Бүх төрлийн байлдаанд ПАЗ-ийн төлөвлөлт хангалтыг зохион байгуулах</p> <p>4. ПАЗ-ийн дунд засварын хэмжээний технологийн үйлдлүүд</p> <p>5. Артиллерийн буунд эвлүүлсэн байдалд үзлэг хийж илэрсэн гэмтлийг засварлах</p> <p>6. Буудлагын зэвсэглэлийг тусгалд оруулах артиллерийн бүх төрлийн бууны хараа хэрэгслийг шалгах тохируулах</p> <p>7. артиллерийн бууны УЭБ, ТЭМ-ийг шалгах тохиргоо хийх</p> <p>8. Хуягт танкийн зэвсэглэлийг байлдаанд бэлтгэх</p> <p>9. Галт хэрэглэлийг гүйцэтгэн цэнэглэх, буудлагад бэлтгэх</p> <p>10. Засварын хөдөлгөөнт хэрэгслийн бүтэц, зохион байгуулалт</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангахаас гадна:</p> <p>1.Засварын хөдөлгөөнт хэрэгслийг дэлгэх журам, ажлын байрны үүргүүд</p> <p>2. Хорооны засварын хөдөлгөөнт хэрэгслийг ашиглан артиллерийн буунд ТҮ№2-ын ажлын багтаажийн хэмжээнд технологийн горимын дагуу гүйцэтгэх ажилбарууд</p> <p>3. Зэвсэглэлийн удаан болон түр хугацааны хадгалалтад тавих, битүүмжлэх, хадгалалтаас гаргах ажиллагааны горим</p> <p>4. Артиллерийн зэвсэглэлийн зарим төрлийн эд ангиудын материалын физик-химийн шинж чанарууд</p> <p>5. Танкийн тогтворжуулагчийг байлдааны ажиллагаанд бэлтгэх, тохиолдож болох саатал гэмтлийг засварлах</p> <p>6. БМ-21, ТЭЗПЦ, ЯЦБМ, Хуягт тээвэрлэгч, ЗПЦ-ын цахилгааны болон механик гэмтэл, саатлыг илрүүлэх, арилгах, байлдааны ажиллагаанд бэлтгэх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагуудыг хангаж байхаас гадна:</p> <p>1.Гадаадын орнуудын зэвсэглэлийг ижил төрлийн зэвсэглэлтэй харьцуулан шинжлэх чадвар</p> <p>2. Зэвсэглэлийн эд анги, механизмуудыг технологийн дагуу сэргээн засварлах тохируулах ажил</p> <p>3. Нарийн төвөгшилтэй эд ангид слесарь механикийн боловсруулалт хийх ажлын горим</p> <p>4. Засварын хөдөлгөөнт хэрэгслийг дэлгэн байрлуулах цахилгааны тэжээлийн холболтын схемийг ашиглах</p> <p>5. Артиллерийн зэвсэглэлийн засварын технологи, засвар хоорондын хугацаа, ашиглалтын нөөц, зэвсэглэлийн хийцийн төсөл, зохиомжийн тооцооны үндэс</p>
---	---	---

б. Ур чадварын түвшин

<p>1.МББР-ын орон тооны зэвсэглэл, тэдгээрийн галт хэрэглэл, гэрэллэг багажны техникийн үйлчилгээг бие даан гүйцэтгэх, гэмтэл саатлыг илрүүлэн арилгах, эдэлхүүнийг цаашид ажиллах эсэхийг тодорхойлох, хянах-хэмжих багаж хэрэгслийн тусламжтайгаар шалгалт тохиргоо хийж чаддаг байх</p> <p>2. ПАЗ-ийн хангалтын тооцоо, төлөвлөлт, баримт бичгүүдийг боловсруулж чаддаг байх</p>	<p>III зэрэгтэнд тавигдах шаардлагуудыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Бүх төрлийн артиллери, зенит, буудлагын зэвсэг, хуягт танкийн зэвсэглэл, гэрэллэг багажны засвар, техникийн үйлчилгээг хийх ажлыг зохион байгуулж чаддаг. засварын хөдөлгөөнт хэрэгслийг дэлгэн байрлуулж чаддаг</p> <p>2. Өөрийн албан тушаалаас нэг шат дээгүүр нэгжийн ПАЗ-ийн хангалтыг зохион байгуулж чаддаг байх</p>	<p>II зэрэгтэнд тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Засварын хөдөлгөөнт хэрэгслийн зарим тоног төхөөрөмжүүдийг ажлын байдалд бэлтгэж чаддаг байх</p> <p>2. Зэвсэглэлийн засвартай эд ангид слесарь механикийн боловсруулалт хийх ба түүний зураг эскизийг боловсруулж чаддаг байх</p>
---	---	---

6. Пуужин, артиллерийн зэвсэглэлийн мэргэжлээр (ахлагч)

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Артиллерийн зэвсэглэлийн зангилгаа, механизмыг тохируулах, засварлах аргууд</p> <p>2. Зэвсэглэлийн задаргаа хийсэн эд анги, зангилгаануудын гэмтлийг тодорхойлох төвөгшил багатай эд ангийг засварлах</p> <p>3. Хянах, хэмжих багаж хэрэгслийн зохион байгуулалт, зориулалт. хэрэглэх журам</p> <p>4. Техникийн үечилсэн үйлчилгээнүүдийн онцлог, түүнд хэрэглэж буй шатахуун, тосолгооны материалын үндсэн шинж чанар</p> <p>5. Артиллерийн бууны УЭБ, ТМ-ийг шалгах. тохиргоо хийх арга</p> <p>6. Галт хэрэглэлийг байлдааны буудлагад бэлтгэх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Артиллерийн зэвсэглэлийн хийц, зохион байгуулалтын онцлог, цахилгаан тоног төхөөрөмжийг засварлах, туршин тохируулах, харьцах эд ангийн элэгдлийн шалтгаан, түүнийг илрүүлэх. арилгах арга</p> <p>2. ТЭЗПЦ, Д10Т2С, ЯЦБМ, Хуягт тээвэрлэгч, ЗПЦ-ын механик болон цахилгааны гэмтлийг тодорхойлох</p> <p>3. Артиллерийн зэвсэглэлийн хараа хэрэгслийг шалгах, тохируулах</p> <p>4. Галт хэрэглэлийг гүйцэтгэн цэнэглэх технологийн ажиллагаа</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Зэвсэглэлд засвар хийх аргууд, засварын дараа нарийвчлэлыг турших шалгах журам, оношлох арга, элэгдсэн эд ангийг бүрэн сэргээх, засварлах аргууд</p> <p>2. Зэвсэглэлийн эд анги, зангилгаануудыг нийтэд нь болон хэсэгчлэн шалгах арга</p> <p>3. Тооллого, бүртгэлийн баримт бичгийг хөтлөх, тайлан тооцоо гаргах журам</p> <p>4. Галт хэрэглэлийн хадгалалтын онцлогууд</p>
--	--	---

б. Ур чадварын түвшин

<p>1. Зэвсэглэлийг эвлүүлсэн ба задалсан байдалд гэмтэл тодорхойлох зарим эд анги, эвлүүлгийг солих, артиллерийн зэвсэглэлд техникийн үйлчилгээг хийж, тохируулах</p> <p>2. Галын бэлтгэлийн бүх нормативуудыг "Сайн"-аас доошгүй дүнтэй биелүүлж чаддаг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Дунд зэргийн төвөгшилтэй зангилгаа, механизмыг засварлах. тохируулах, техникийн нөхцлийн дагуу хүлээлгэн өгөх</p> <p>2. Тусгай аппаратур, багаж хэрэгслийг ашиглан цахилгаан болон бусад тоног төхөөрөмжийг шалгаж тохируулах</p> <p>3. Засварын хөдөлгөөнт хэрэгслийн тусламжтайгаар токарын боловсруулалт хийх. эд ангийг тохируулах, гагнуур хийх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Зэвсэглэлийг техникийн нөхцлийн дагуу засварлах, цахилгаан, механик, шахуургат зангилгааг техникийн нөхцлийн дагуу оношлох, засварлах ажил</p>
---	--	---

7. Авто, хуягт танкийн инженер, техникийн мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Монгол Улсын цэргийн урлаг, инженер-техникийн онолын үндэс</p> <p>2. Бригад хүртэлх ангиудын байлдааны ажиллагаанд техникийн хангалтыг зохион байгуулж, удирдаж явуулах</p> <p>3. Гадаадын орнуудын авто хуягт танкийн техник, тэдгээрийн засварын хүч хэрэгслийн байлдааны боломж. тактик техникийн өгөгдөхүүн</p> <p>4. Техникийн анги, салбарын КШС, ТЖС-ийг төлөвлөж удирдан явуулах</p> <p>5. Техникийн анги салбаруудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндэс, тэдгээрийг</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Бригадын байлдааны ажиллагааны техникийн хангалтад гарч буй шинэлэг зүйлүүд</p> <p>2. Гадаадын орнуудын авто хуягт танкийн техник, тэдгээрийн засварын хүч хэрэгсэлд гарч буй хөгжлийн шинэлэг хандлагууд</p> <p>3. Техникийн хангалт, онолын үндэсийг амьдралд ашиглах мэдлэг</p> <p>4. Зэвсэглэл техникийг түр болон удаан</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Цэргийн шинжлэх ухаан, түүний инженер техникийн бүрэлдэхүүн хэсгүүд, тэдгээрийг судлах зүйл</p> <p>2. Нэгтгэл, ангийн техникийн хангалтыг дээшлүүлэх арга замууд</p> <p>3. Энхийг дэмжих ажиллагааны техникийн хангалт</p> <p>4. Зэвсэглэл техникийн бэлэн байдалд үзлэг явуулах</p>
--	--	---

<p>дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах баримт бичиг тооцоо</p> <p>6. Техникийн анги салбарын засварын хүч хэрэгслийн бүтэц, бүрэлдэхүүн, хүчин чадал</p> <p>7. Техникийн хангалтын онолын үндэс</p> <p>8. Сэлбэг хэрэгслийн нөөц, тэдгээрийн терлүүд, үүрэг зориулалт</p> <p>9. Авто хуягт танкийн техник түүний эд ангиудын үүрэг зориулалт. бүтэц, бүрэлдэхүүн</p> <p>10. Авто хуягт танкийн техникийг засварлах болон хадгалах технологи</p> <p>11. Металл боловсруулалтын онолын үндэс</p> <p>12. Техник хангалтын талаар гарсан удирдлагын бичиг баримтууд</p> <p>13. Техникт хийх үзлэг, үйлчилгээний дараалал, ажлын багтаамж /ССТУ/</p> <p>14. Тавиулангийн элементүүдийн зохион байгуулалт, түүний үйл ажиллагаа</p>	<p>хугацааны хадгалалтад тавих, хадгалалтаас гарах</p> <p>5. Авто хуягт танкийн техник, түүний эд ангийн онолын үндэс</p> <p>6. Тавиулангийн элементүүдийг зохион бүтээх онолын тооцоо</p> <p>7. Техникийн гэмтлийг илрүүлэх оношлолын онолын үндэс</p>	<p>5. Техникийн анги, салбаруудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндэс</p>
---	---	--

6. Ур чадварын түвшин

<p>1. Техник хангалтын баримт бичгүүдийг тогтоосон шаардлага, стандартын дагуу боловсруулах</p> <p>2. Техникийн бэлтгэлийн нормативуудыг боловсруулж чаддаг</p> <p>3. Засварын хүч хэрэгслийг газар орон дээр дэлгэн байрлуулах чадвартай байх</p> <p>4. Техник технологийн дагуу хадгалалтад шилжүүлэх, хадгалалтнаас гаргаж чаддаг байх</p> <p>5. Техникт хийгдэх түвэгшил багатай засваруудыг хийж чаддаг байх</p> <p>6. Техникийн анги, салбарын КШС, ТЖС-ийг төлөвлөж удирдах чадвартай байх</p> <p>7. Нэгтгэл ангийн техникийн хангалтыг төлөвлөн зохион байгуулж чаддаг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Газар орон дээр дэлгэн байрлуулсан засварын хүч хэрэгслийн тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх</p> <p>2. Зэвсэглэл техникийн гэмтлийг илрүүлэх оношлолын багаж хэрэгслийг ашиглаж чаддаг байх</p> <p>3. Багаж тоног төхөөрөмж шаардсан түвэгшил ихтэй нарийн засваруудыг хийж чаддаг байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Зэвсэглэл техникийн бэлэн байдалд үнэлэлт өгч чаддаг байх</p> <p>2. Засварын технологийн процессийг мэдэж зураг төслийг боловсруулж чаддаг байх</p>
---	--	--

8. Авто хуягт танкийн засварчин мэргэжлээр

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Засварын онолын үндэс</p> <p>2. Техникийн бүтэц, зохион байгуулалт, тэдгээрт байрласан тусгай зориулалтын багаж төхөөрөмж, үүрэг хүчин чадал</p> <p>3. Засварын тоног төхөөрөмжийн нэр төрөл, үүрэг зориулалт, боломж</p> <p>4. Авто хуягт танкийн техникт урсгал болон дунд засварыг хийж технологийн дараалал ажиллагааны зарчим</p> <p>5. Засварын үеийн техникийн аюулгүй ажиллагааны дүрэм заавар</p> <p>6. Сэргээн сайжруулах техникийн үйлчилгээний онолын үндэс</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Гагнуурын ажлын онолын мэдлэг</p> <p>2. Зай хураагуур засварын онолын мэдлэг</p> <p>3. Авто хуягт танкийн техникийн цахилгаанчны онолын мэдлэг</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Бүх төрлийн цэргийн авто хуягт танкийн техникийн засварын онолын үндэс</p>
---	--	---

6. Ур чадварын түвшин		
<p>1. Бүх төрлийн техникт ССТУ-г хийж чаддаг байх</p> <p>2. Техникт хийгдэх түвэгшил багатай засваруудыг хийж чаддаг байх</p> <p>3. Засварын тоног төхөөрөмжийг ашиглах чадвартай байх</p> <p>4. Засварын хөдөлгөөнт хүч хэрэгслийг дэлгэн байрлуулж чаддаг байх</p> <p>5. Завсарын тоног төхөөрөмжинд үйлчилгээ хийдэг дадлагатай байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Техникийн гэмтлийг илрүүлэх оношлолын багаж тоног төхөөрөмжийг ашиглаж чаддаг</p> <p>2. Багаж тоног төхөөрөмж шаардсан түвэгшил ихтэй нарийн засваруудыг хийх чадвартай байх</p> <p>3. Шинээр засварчны мэргэжил эзэмшигчдэд дадлага олгох туршлагатай байх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Бүх төрлийн цэргийн авто, хуягт танкийн техникийг засварлах чадвартай байх</p>
9. Цэргийн эмнэлгийн команд		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Ерөнхий цэргийн байлдааны үндэс</p> <p>2. Байлдааны үеийн эмнэлгийн бүх төрлийн хангалтын төлөвлөлт, хангалт</p> <p>3. Цэргийн эмнэлгийн зохион байгуулалт, удирдлага</p> <p>4. Цэргийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ</p> <p>5. Бүх төрлийн ар талын үйлчилгээ, худалдааны үндсэн ойлголт</p> <p>5. Цэргийн эмнэлгийн тусгай зориулалтын техник, табель хэрэгсэл, цувраажилтын норм</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндэс</p> <p>2. Ар тал, техникийн анги, салбар, бүлгийн зохион байгуулалт, үүрэг</p> <p>3. Байлдааны төрөл тус бүрийн эмнэлгийн хангалт</p> <p>4. Цэргийн эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээний хангалт</p> <p>5. Энхийг дэмжих болон хүмүүнлэгийн ажиллагааны эмнэлгийн хангалтуудыг удирдаж, зохион байгуулах чадвартай байх</p> <p>6. Анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн эмнэлгийн хангалт</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчний дэлгэн байгуулалт, шилжүүлэн бүлэглэлтийн үе дэх эмнэлгийн хангалт</p> <p>2. Улсын дайчилгаа, эдийн засгийн эрүүл мэндийн чадавхийг цэргийн зориулалтаар ашиглах боломж</p> <p>3. Нэгтгэл, анги, цэргийн бүлэглэлийн эмнэлгийн хангалтын удирдлага</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндсэн зарчимд тулгуурлан цэргийн эмнэлгийн бүтцийн нэгжүүдийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах ажлыг удирдах чадвартай байх</p> <p>2. Анги, салбаруудын эмнэлгийн КШХС-ийн бодлого, эмнэлгийн тактик, тусгай бэлтгэлийг төлөвлөх, удирдаж явуулах дадлага эзэмшсэн байх</p> <p>3. Анги, салбаруудын эмнэлгийн орон тоо, зохион байгуулалт, табель хэрэгслийг гүйцэтгэх үүрэгт нь зохицуулан тооцож чаддаг байх</p> <p>4. Цэргийн эмнэлгийн бүх төрлийн нормативуудыг биелүүлдэг байх</p> <p>5. Эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийн засвар, үйлчилгээг хийж чаддаг байх</p> <p>6. Тайван ба байлдааны цагт эмнэлгийн эм, хэрэгслийн хангалтыг удирдан зохион байгуулах чадвар эзэмшсэн байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Эмнэлгийн хангалтын бүх төрлийн тооцоог хийж, бичиг баримт боловсруулах</p> <p>2. Цэргийн эмнэлгийн байгууллагуудыг алсын болон ойрын зайд газар, агаар, усан замаар тээвэрлэж, шилжүүлэн байрлуулах төлөвлөлт, зохион байгуулах</p> <p>3. Анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн эмнэлгийн хангалтыг төлөвлөх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчний дэлгэн байгуулалт, шилжүүлэн бүлэглэлтийн үе дэх эмнэлгийн хангалтыг төлөвлөх, зохион байгуулах</p> <p>2. Нэгтгэл, анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн эмнэлгийн хангалтыг төлөвлөх, зохион байгуулах</p>

10. Цэргийн эмнэлгийн их эмч

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Ерөнхий цэргийн байлдааны үндэс 2. Цэргийн эмнэлгийн тактик, зохион байгуулалтын үндэс 3. Цэргийн эрүүл ахуй, халдвар судлалын үндэс 4. Цэргийн эмнэлгийн бүх төрлийн нормативыг биелүүлдэг байх 5. Цэргийн эмнэлгийн техник, табель хэрэгслийн хүчин чадал, боломжийг мэддэг 6. Бригад, хорооны эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний онолын мэдлэгтэй</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна: 1. Бригад, хороо, батальоны эмнэлгийн хангалтын тооцоог хийж, бичиг баримт боловсруулах 2. Цэргийн эмнэлгийн байгууллагуудыг алсын болон ойрын зайд газар, агаар, усан замаар тээвэрлэж, шилжүүлэн байрлуулах төлөвлөх 3. Анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн эмнэлгийн хангалтыг төлөвлөх 4. Эмнэлгийн цувраажилтын нормын дагуу бригад, хороо, батальоны эмнэлгийн хангалтыг төлөвлөх 5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн анхан шатны засвар үйлчилгээ хийх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна: 1. Байлдааны цагт өөрийн гүйцэтгэх албан тушаалаас 1 шат дээгүүр албан тушаалын үүрэг гүйцэтгэх мэдлэгтэй байх 2. Нэгтгэл, анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн эмнэлгийн хангалтыг төлөвлөх, зохион байгуулах 3. Байлдааны цагийн госпиталийн удирдлага зохион байгуулалтын мэдлэг эзэмшсэн байх</p>
--	--	--

б. Ур чадварын түвшин

<p>1. Хороо, батальоны эмнэлгийн тоног төхөөрөмжийг ажиллуулдаг, засвар үйлчилгээ хийж чаддаг байх 2. Бие бүрэлдэхүүнд нийгмийн эрүүл мэнд, төрөлжсөн нарийн мэргэжлийн чиглэлээр хичээл сургалт явуулах 3. Батальоны эмнэлгийн хангалтыг зохион байгуулах чадвартай 4. Цэргийн эмнэлгийн бүх төрлийн нормативуудыг биелүүлдэг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна: 1. Бригадын эмнэлгийн хангалтын тооцоог хийж, бичиг баримт боловсруулах 2. Цэргийн эмнэлгийн байгууллагуудыг алсын болон ойрын зайд газар, агаар, усан замаар тээвэрлэж, шилжүүлэн байрлуулах төлөвлөх 3. Анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн эмнэлгийн хангалтыг төлөвлөх 4. Эмнэлгийн цувраажилтын нормын дагуу бригад, хороо, батальоны эмнэлгийн хангалтыг төлөвлөх 5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн анхан шатны засвар үйлчилгээ хийх</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна: 1. Байлдааны цагт өөрийн гүйцэтгэх албан тушаалаас 1 шат дээгүүр албан тушаалын үүрэг гүйцэтгэх мэдлэгтэй байх 2. Анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн эмнэлгийн хангалтыг төлөвлөх, зохион байгуулах 3. Байлдааны цагийн Хүн эмнэлгийн тусгай отрядын удирдлага зохион байгуулалтын мэдлэг эзэмшсэн байх</p>
---	--	--

11. Цэргийн эмнэлгийн бага мэргэжилтэн (бага эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ариун цэврийн орон тооны зааварлагч)

а. Мэдлэгийн түвшин

<p>1. Цэргийн эмнэлгийн эмчилгээ, татан гаргалтын мэдлэгтэй 2. Хороо, батальоны эмнэлгийн тоног төхөөрөмжийн талаар мэдлэгтэй, өөрийн хариуцсан тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ хийж чаддаг байх 3. Бие бүрэлдэхүүнд нийгмийн эрүүл мэнд, төрөлжсөн сувилахуйн чиглэлээр хичээл сургалт явуулах 4. Батальоны эмнэлгийн хангалтын мэдлэгтэй 5. Цэргийн эмнэлгийн бүх төрлийн нормативуудыг биелүүлдэг байх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна: 1. Бригадын эмнэлгийн эмчилгээ, татан гаргалтын мэдлэгтэй 2. Цэргийн эмнэлгийн байгууллагуудыг алсын болон ойрын зайд газар, агаар, усан замаар тээвэрлэж, шилжүүлэн байрлуулах үеийн сувилахуйн тусламжийг зохион байгуулах 3. Анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн сувилахуйн тусламжийг төлөвлөх 4. Эмнэлгийн цувраажилтын нормын дагуу хороо,</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна: 1. Байлдааны цагт өөрийн гүйцэтгэх албан тушаалаас 1 шат дээгүүр албан тушаалын үүрэг гүйцэтгэх мэдлэгтэй байх 2. Анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн сувилахуйн тусламжийг төлөвлөх, зохион байгуулах 3. Байлдааны цагийн Хүн эмнэлгийн тусгай отряд, госпиталийн сувилахуйн удирдлага зохион байгуулалтын мэдлэг эзэмшсэн байх</p>
--	---	--

	<p>батальоны эмнэлгийн сувилахуйн тусламжийг төлөвлөх</p> <p>5. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн анхан шатны засвар үйлчилгээ хийх</p>	
6. Ур чадварын түвшин		
<p>1. Батальоны эмнэлгийн эмчилгээ, татан гаргалтын сувилахуйн тусламжийг бүрэн хэмжээгээр үзүүлж чаддаг</p> <p>2. Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийг сахиулах чадвартай</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Бригадын эмнэлгийн сувилахуйн тусламжийг зохион байгуулах</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Байлдааны цагт өөрийн гүйцэтгэх албан тушаалаас 1 шат дээгүүр албан тушаалын үүрэг гүйцэтгэх мэдлэгтэй байх</p> <p>2. Анги, салбарыг сэргээн босгох, шинээр байгуулах үеийн сувилахуйн тусламжийг үзүүлж чаддаг</p> <p>3. Байлдааны цагийн Хүн эмнэлгийн тусгай отряд, госпиталийн сувилахуйн удирдлагыг хэрэгжүүлэх</p>
12. Цэргийн эдийн засагч		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Ерөнхий цэргийн байлдааны үндэс өөрийн албан тушаалд чадварлаг ашиглах онолын мэдлэг эзэмшсэн байх</p> <p>2. Бүх төрлийн байлдааны санхүүгийн хангалтын онцлог</p> <p>3. Цэргийн санхүүгийн зохион байгуулалт</p> <p>4. Санхүүгийн төлөвлөлт, хангалт</p> <p>5. Төрөл бүрийн байлдааны санхүүгийн хангалт</p> <p>6. Байлдааны ажиллагааны үе дэх албаны даргын үүрэг ажлын дараалал</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Материал хэрэгслийн нөөцийн ангилал, зориулалт, цувраажилтын норм</p> <p>2. Тайван ба байлдааны цагт нэг хүн, нэгж техникт зарцуулагдах материал хэрэглэл</p> <p>3. Бараа бүтээгдэхүүний химийн найрлага, бүтэц шинж чанар, төрөл, ангилал, зориулалт</p>	<p>II, III дугаар зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэх үеийн эдийн засгийн төлөвлөлт, санхүүгийн хангалт</p> <p>2. Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлт</p> <p>3. Ар талын анги, салбарын зохион байгуулалт, ашиглах зарчим</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийн үндсэн зарчмыг гүнзгий мэдэж, анги, салбаруудыг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах үеийн санхүүгийн хангалтыг зохион байгуулах</p> <p>2. Зэвсэгт хүчний анги, салбаруудын орон тоо зохион байгуулалт, шаардагдах санхүүгийн тооцоог анги, салбарын гүйцэтгэх үүрэгт зохицуулан тооцох</p> <p>4. Тайван ба байлдаан цагт санхүүгийн хангалтыг удирдан зохион байгуулах</p> <p>5. Ар талын техник, тоног төхөөрөмжийн улирлын болон сэргээн сайжруулах үйлчилгээ, засвар хийх</p> <p>6. Нэгтгэл, анги, салбаруудын КШХС-д ар талын зүгээс хийгдэх төлөвлөлт, баримт бичгийг боловсруулж чаддаг байх</p> <p>8. Тайван ба байлдаан цагийн материал хэрэглэлийн</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Ар талын хангалтын бүх төрлийн тооцоо хийх</p> <p>2. Тайван ба байлдааны цагт нэг нэгж техникт зарцуулагдах материал хэрэгслийн тооцоог бодож тооцоолох</p> <p>3. Материал хэрэгслийн нөөцийг цувраажилтын нормын дагуу тооцоолж, хангалтыг зохион байгуулах чадвартай байх</p> <p>4. Материал хэрэгслийн хорогдлыг нормын дагуу тооцох</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангахаас гадна:</p> <p>1. Зэвсэгт хүчнийг дайны байдалд шилжүүлэх үеийн эдийн засгийн төлөвлөлтийг хийх, санхүүгийн хангалтыг зохион байгуулах</p> <p>2. Ар талын хангалтын тооцоог хэд хэдэн хувилбараар боловсруулах</p> <p>3. Ар талын байлдааны болон дайчилгааны бэлэн байдлын төлөвлөлтийг боловсруулах</p> <p>4. Тайван болон дайны цагт ар талын анги, салбарын ажиллагааг зохион байгуулах</p>

<p>хангалтын тооцоог хийх</p> <p>9. Ар талын бие бүрэлдэхүүнд заагдах тусгай бэлтгэлийн хичээлийг удирдан явуулах</p> <p>10. Материал хэрэглэлийн чанар байдлыг тодорхойлох</p>		
---	--	--

Арав. Цэргийн соёл хүмүүжлийн мэргэжлээр

III зэрэг	II зэрэг	I зэрэг
1. Ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтын мэргэжилтэн		
а. Мэдлэгийн түвшин		
<p>1. Дайн, цэргийн урлагийн түүх, Монгол Улсын цэргийн урлаг, Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудыг зэвсэгт тэмцэлд ашиглах онолын үндэс</p> <p>2. Хөрш болон дэлхийн томоохон гүрнүүдийн цэргийн стратеги-оперативийн үндэс</p> <p>3. Монгол Улсын Төрийн батлан хамгаалах бодлого, түүний үндсэн баримт бичгүүдийн агуулга</p> <p>4. Бригадын үндсэн төрлийн байлдааны ёс суртахуун, сэтгэлд зүйн ажиллагааны үндэс</p> <p>5. Нэгтгэл, анги, салбарын ёс суртахуун, сэтгэлд зүйн бэлэн байдал, дайчилгааны үндэс</p> <p>6. Олон улсын болон Монгол Улсын хууль эрх зүйн онолын үндэс</p> <p>7. Байлдаан болон тайван цагийн ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтын зохион байгуулалтын үндэс</p> <p>8. Ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтын баримт бичгүүдийн агуулга, боловсруулах журам</p> <p>9. Гадаадын орнуудын армийн сэтгэл зүйн хангалтын боломж, оператив, тактикийн ажиллагааны үндэс</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Монгол Улсын цэргийн урлагийн хөгжлийн чиг хандлага</p> <p>2. Хөрш болон дэлхийн томоохон гүрнүүдийн цэргийн стратегийн хөгжил</p> <p>3. Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо үзэл баримтлал, үндэсний цэргийн стратеги</p> <p>4. Зэвсэгт хүчний мэдээлэл, сэтгэл зүйн ажиллагааны үндэс</p> <p>5. Нэгтгэл, анги, салбарын сэтгэл зүйн байдлын боломжийг тооцох аргачлал</p> <p>6. Нэгтгэл, анги, салбарын сэтгэл зүйн чадварыг нөхөн сэргээх арга хэмжээ</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Монгол Улсын болон Зэвсэгт хүчний нийгэм сэтгэл зүйн үнэлэлт, дүгнэлт</p> <p>2. Дэлхийн улс орнуудын цэрэг, улс төрийн болон мэдээлэл-сэтгэл зүйн байдал, хөгжлийн чиг хандлага</p> <p>3. Бүс нутгийн болон орон нутгийн мэдээллийн дайн, зэвсэгт мөргөлдөөний туршлага, сургамж</p> <p>4. Түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг нийгэм-сэтгэл зүйн хувьд бэлтгэх үндэс</p> <p>5. Зэвсэгт хүчний ёс суртахуун, сэтгэл зүйн боломжийг дээшлүүлэх арга замууд</p> <p>6. Батлан хамгаалах салбарын холбогдох хууь эрх зүйн үндэс</p>
б. Ур чадварын түвшин		
<p>1. Зураг дээр болон газар орон дээр ёс суртахуун, сэтгэл зүйн байдлын цагийн байдлыг тогтоон ажиллагааны хувилбаруудыг гаргадаг байх</p> <p>2. Мбб-ны түвшинд ёс суртахуун, сэтгэл зүйн ажиллагааны саналыг гаргаж, ахлах даргад илтгэх, анги, салбаруудад байлдааны үүрэг тавих</p> <p>3. Байлдааны болон тайван цагийн ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтын зохион байгуулалтын баримт бичгүүдийг тогтсон шаардлага, стандартын дагуу боловсруулж чаддаг байх</p> <p>4. Төрөл бүрийн тооцоо, санал, шийдвэрийг илтгэх</p>	<p>III зэрэгт тавигдах шаардлагуудыг хангасан байхаас гадна:</p> <p>1. Мббр-ын түвшинд ёс суртахуун, сэтгэл зүйн байдлын төрөл бүрийн тооцоо хийх</p> <p>2. Соёл гэгээрлийн техник, хэрэгслээр болон биеэр анги, салбарын ёс суртахуун, сэтгэл зүйн ажиллагааг удирдах, харилцан ажиллагааг зохион байгуулах</p> <p>3. Өөрийн болон эсрэг талын ёс суртахуун, сэтгэл зүйн байдлын боломжийг тооцох</p>	<p>II зэрэгт тавигдах шаардлагыг хангаж байхаас гадна:</p> <p>1. Түрэмгийллийг няцаахад зэвсэгт хүчнийг нийгэм-сэтгэл зүйн хувьд бэлтгэх</p> <p>2. Ерөнхий зориулалтын цэрэг, нэгтгэлийн түвшинд ёс суртахуун, сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах санал боловсруулах, иргэн-цэргийн харилцааг зохион байгуулах</p> <p>3. Сэтгэл зүйн удирдлагын байран дээр удирдлагын байгууллагын ажиллагааг зохион байгуулах</p>

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ОФИЦЕР, АХЛАГЧ, ГЭРЭЭТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧДААС
МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ШАЛГАЛТ АВАХ ЖУРАМ

1. Зэвсэгт хүчинд цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтыг зохион байгуулахад Батлан хамгаалахын сайдын 2012 оны а/150 дугаар тушаалаар батлагдсан “Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид мэргэжлийн зэрэг олгох журам” болон энэхүү тушаалыг мөрдлөг болгоно.

2. Цэргийн мэргэжлийн зэргийн шалгалтыг Зэвсэгт хүчний цэргийн сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөө, ЗХЖШ, командлал, анги, байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу зохион байгуулна.

3. Мэргэжлийн зэргийн шалгалтыг төв ба салбар комиссын даргын баталсан тусгай хуваариар, эсвэл сургуулийн жилийн төгсөлтийн болон цогцолбор шалгалтаар хамтатган зохион байгуулна.

4. “Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид мэргэжлийн зэрэг олгох журам”-ын гуравдугаар зүйлд заасан мэргэжлийн зэрэгтэнд тавигдах шаардлагуудыг хангаж байгаа цэргийн алба хаагчийн холбогдох материалд хийсэн үнэлгээ, дүгнэлтийг үндэслэн түүнийг зэргийн шалгалтад хамруулна.

5. Мэргэжлийн зэрэгтэнд тавигдах шаардлагуудын аль нэгийг хангаагүй болон зэрэг эзэмших, зэргээ хамгаалах, ахиулахын тулд төв болон салбар комисст ирүүлэх баримт бичгийг дутуу бүрдүүлсэн бол тухайн цэргийн алба хаагчийг шалгалтад хамруулахгүй.

6. Мэргэжлийн зэргийн шалгалтад орохоор хүсэлт гаргасан цэргийн алба хаагчийн оюуны чадавхийн үнэлгээ нь нууц байх бөгөөд үүнийг тусгайлан битүүмжилж төв комисст бичгээр ирүүлнэ.

7. Мэргэжлийн зэргийн шалгалтад орох бүрэлдэхүүний тодорхойлолтыг энэхүү тушаалын дөрөвдүгээр хавсралтын дагуу үйлдэх бөгөөд түүнд тухайн цэргийн алба хаагчийн хамгийн сүүлд авсан шалгалтын үнэлгээг бичнэ.

8. Мэргэжлийн зэргийн шалгалт нь онолын ба ур чадварын шалгалтаас бүрдэнэ. Шалгалтыг онол, дадлагын хэлбэрээр, тест, бодлого бодох, асуултад амаар болон бичгээр хариулт өгөх, тактикийн шуурхай дадлага боловсруулах, төрөл бүрийн дасгал, норматив, байлдааны буудлага, харвалт, нислэг, жолоодлого үйлдүүлэх зэрэг тухайн мэргэжлийн мэдлэгийн ба ур чадварын шалгуур үзүүлэлтэд тохирсон аргаар зохион байгуулна.

9. Мэргэжлийн зэргийн шалгалтад орохоор хүсэлт гаргасан цэргийн алба хаагч нь цогцолбор болон командлалын шалгалтад хамрагдсан, түүнчлэн болон гадаад хэлний бэлтгэлийн түвшингээ урьдчилан тогтоолгосон байна.

10. Төв болон салбар комисс нь шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн зэрэгтэнд тавигдах шаардлагуудын хүрээнд нэмэлт шалгалтыг явуулж болно.

11. Шалгалтад тухайн цэргийн алба хаагчийн мэргэжлийнхээ дагуу амжилттай гүйцэтгэсэн байлдааны үүргийн болон сургуулийн дасгал, нислэг, буудлага, жолоодлого, харвалтын үнэлгээг харгалзан үзэж, төв комиссын шийдвэрээр ур чадварын шалгалтад

тэнцсэн гэж үзэж болно. Энэ тохиолдолд тухайн цэргийн алба хаагчаас онолын шалгалт авна.

12. Эзэмшсэн мэргэжлээрээ цэргийн шинжлэх ухаанаар магистр, докторын зэрэг хамгаалсан цэргийн алба хаагч нь мэргэжлийн зэрэг шинээр эзэмших, хамгаалах, ахиулах үедээ онолын шалгалт өгөхгүй байж болох бөгөөд энэ тохиолдолд зөвхөн ур чадварын шалгалт өгнө.

13. Шалгалтын тест, дадлагын ажлын асуулт, даалгавар, дасгал, нормативуудыг цэргийн мэргэжлийн зэрэгтэнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн төрөл мэргэжлийн газар, хэлтэс, командлал, албадын дэмжлэгтэйгээр төв болон салбар комисс боловсруулна.

14. Онолын болон ур чадварын шалгалтын аль нэг асуулт, даалгавар, дасгал, нормативыг “С” буюу түүнээс доогуур үнэлгээтэй биелүүлсэн тохиолдолд тухайн цэргийн алба хаагчийг шалгалтад тэнцээгүйд тооцно

АЖИЛЛАГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР

ЦЭРГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРГИЙН ШАЛГАЛТАД ОРОХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ
ТОДОРХОЙЛОЛТ

1. Овог: _____

2. Эцгийн нэр: _____

3. Нэр: _____

4. Регистрийн дугаар:

--	--	--	--	--	--	--	--	--	--

5. Алба хаасан хугацаа (жилээр): _____

6. Мэргэжил: _____

7. Цол, одоогийн албан тушаал, томилогдсон огноо, тушаалын дугаар: _____

Зураг
3x4см

8. Эрдмийн зэрэг (зур): *а. Доктор* *б. Магистр*

9. Командлалын болон цогцолбор шалгалтын үнэлгээ (үсгэн болон тоон дүнгээр): _____

10. Төрийн алба хаагчийн жилийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлт: _____

11. Гадаад хэлний бэлтгэлийн түвшин (ямар хэлийг, ямар түвшинд эзэмшсэн): _____

12. Хувийн зэвсгээр буудах дадлага (үсгэн болон тоон дүнгээр): _____

13. Бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин (үсгэн болон тоон дүнгээр): _____

14. Мэргэжлийн бэлтгэлийн үнэлгээ (үсгэн болон тоон дүнгээр): _____

15. Ямар мэргэжлээр зэрэг эзэмших: _____

16. Мэргэжлийн зэргийн шалгалтын төрөл (зур):

а. Шинээр эзэмших *б. Хамгаалах* *в. Ахиулах*

17. Ямар шалгалтад оруулах (зур): *а. I зэрэг* *б. II зэрэг* *в. III зэрэг*

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

Тамга ЗАХИРАГЧ _____ / _____ /

(цол, гарын үсэг, нэр)

_____ /
(он, сар, өдөр)